



АВЛИГАГҮЙ НИЙГМИЙН ТӨЛӨӨХ ИРГЭДИЙН ХЯНАЛТ



Улаанбаатар 2024





АВЛИГАГҮЙ НИЙГМИЙН ТӨЛӨӨХ ИРГЭДИЙН ХЯНАЛТ

(Сургалтын гарын авлага)



Улаанбаатар

2024

Энэхүү гарын авлагыг Авлигын эсрэг үндэсний хөтөлбөрийн хэрэгжүүлэх хүрээнд Авлигатай тэмцэх газрын захиалгаар “Эмэгтэйчүүд, Залуучуудын Оюуны сан Үнлэсний сүлжээ” ТББ-ын зөвлөх баг бүтээв. Тус бүтээлд илэрхийлсэн агуулга нь зохиогчдын үзэл санаа бөгөөд Авлигатай тэмцэх газрын албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.

Боловсруулсан:

Ц.Бүжидмаа (доктор Ph.D)
Ч.Сосормаа (MPA)

Модуль 1, 3
Модуль 2

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ЗГХЭГ	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
АТГ	Авлигатай тэмцэх газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИНБ	Иргэний нийгмийн байгууллага
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ИНХ	Иргэдийн Нийтийн Хурал
НҮБХХ	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр
НЭХ	Нийгмийн эгэх хариуцлага
ЭЗОС	Эмэгтэйчүүд, Залуучуудын Оюуны Сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТББ	Төрийн бус байгууллага
УИХ	Улсын Их Хурал

МОДУЛИЙН ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА

Сургалтын модулийн зорилго, зорилтууд:

Зорилго. Авлигатай тэмцэх үйл ажиллагаанд иргэдийн оролцоо, түүний ач холбогдол, иргэдийн хяналтыг хэрэгжүүлэх арга замуудын талаар оролцогчдын мэдлэг ойлголтыг нэмэгдүүлж, иргэдийн хяналтыг хэрэгжүүлэх ур чадвар эзэмшүүлэхэд энэхүү сургалтын модулийн зорилго оршино.

Зорилтууд:

1. Оролцогчдод авлигатай тэмцэх үйл ажиллагаанд иргэдийн оролцоо, түүний ач холбогдол, сайн туршлагын талаар мэдлэг, мэдээлэл олгох
2. Авлигын эсрэг иргэдийн хяналтын механизмын талаар мэдлэг олгож, иргэдийн хяналтын бүлэг байгуулах аргачлалд сургах
3. Авлигын эсрэг иргэдийн хяналтын зарим арга хэрэгсэл, авлигын эсрэг кампанит ажил зохион байгуулах мэдлэг, ур чадвар олгох

Хүрэх дүн:

- Төрийн үйл ажиллагаанд иргэд, иргэний нийгмийн байгууллагын хяналтыг хэрэгжүүлэх, бүтээлчээр оролцох хүсэл тэмүүлэлтэй болсон байна.
- Багийн ИНХ-ын дэргэд иргэдийн хяналтын бүлэг байгуулах аргачлалд суралцана.
- Оролцогчид нийгмийн аудитийн явц, тайлан гаргах аргад суралцаж, ил тод байдлыг дэмжих арга замуудыг ойлгоно.
- ИТХ-ын хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэхэд иргэдийн оролцоо нэмэгдүүлэх замаар авлигаас урьдчилан сэргийлэх, иргэдийн оролцоог нэмэгдүүлэхэд бодит үр дүнгүүд гарна.

Модулаар эзэмших ур чадвар:

- Авлигатай тэмцэх үйл ажиллагаанд иргэдийн оролцооны ач холбогдол, цахим оролцооны арга хэлбэрүүд, иргэдийн хяналтын бүлгийн талаар мэдлэгтэй болно.
- Авлигатай тэмцэх үйл ажиллагаатай холбоотой асуудал, бэрхшээл, шалтгаан, шийдлийг тодорхойлох ур чадварт суралцана.
- Авлигын эсрэг кампанит ажлыг төлөвлөх зохион байгуулах ур чадварт суралцана.

Модуль тус бүрийн дэлгэрэнгүй танилцуулгыг хүснэгт 1.1-т харууллаа.

Хүснэгт 1.1. Модулийн дэлгэрэнгүй танилцуулга

Модуль	Хичээлүүд	Дэд сэдэв	Хугацаа
Модуль 1. "Авлигатай тэмцэх үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангах нь" 8 цаг	Хичээл 1.1. Авлигатай тэмцэх үйл ажиллагаанд иргэдийн оролцооны ач холбогдол	<ul style="list-style-type: none"> • Иргэдийн оролцооны ач холбогдол, тэдгээрийн авлигын эсрэг үйл ажиллагаанд үзүүлэх нөлөө. • Авлигын эсрэг иргэдийн санаачилга, сайн туршлагууд 	3 цаг
	Хичээл 1.2. Авлигатай тэмцэх үйл ажиллагаандах иргэдийн цахим оролцоо	<ul style="list-style-type: none"> • Цахим оролцооны хэлбэрүүд, цахим оролцооны үр нөлөө • Цахим оролцоог нэмэгдүүлэх арга замууд 	2 цаг
	Хичээл 1.3. Авлигатай тэмцэх иргэдийн оролцооны бусад хэлбэрүүд	<ul style="list-style-type: none"> • Шүгэл үлээх буюу мэдээлэгчийн үүрэг • Олон нийтийн хэлэлцүүлэг ба сонсгол • Иргэдийн хяналт 	3 цаг
Модуль 2 Авлигын эсрэг иргэдийн хяналтын механизм 8 цаг	Хичээл 2.1. Иргэдийн хяналтын бүлэг	<ul style="list-style-type: none"> • Иргэдийн хяналтын бүлэг юуг хянах вэ? • Иргэдийн хяналтын бүлгийг байгуулах • Иргэдийн хяналтыг хэрэгжүүлэх үе шат 	4 цаг
	Хичээл 2.2. ИТХ-ын хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэхэд иргэдийн оролцоо	<ul style="list-style-type: none"> • ИТХ-ын дэргэд Төсвийн хяналтын хороо байгуулах аргачлал 	2 цаг
	Хичээл 2.3. Төсвийн хяналтын сонсгол зохион байгуулах арга зүй	<ul style="list-style-type: none"> • Нийтийн сонсгол гэж юу вэ? • Сонсголын төрөл • Төсвийн хяналтын сонсгол зохион байгуулах арга зүй 	2 цаг
Модуль 3 Авлигын эсрэг иргэдийн хяналт, оролцоог нэмэгдүүлэх зарим арга хэрэгслүүд 8 цаг	Хичээл 3.1. Нийгмийн аудит	<ul style="list-style-type: none"> • Нийгмийн аудит гэж юу вэ • Нийгмийн аудит хийх алхмууд 	4
	Хичээл 3.2. Авлигын эсрэг кампанит ажил	<ul style="list-style-type: none"> • Авлигын эсрэг кампанит ажил • Авлигын эсрэг кампанит ажлыг зохион байгуулах алхмууд 	4
Нийт			24 цаг

Арга зүй:

- Сургалтын явцад тухайн модулийн агуулгын хүрээнд багшийн мэдээлэл, онолын мэдлэг олгох сургалтыг практиктай хослуулах, суралцагчдын бүтээлч оролцоо, ур чадварыг эзэмшүүлэхэд чиглэсэн мэдлэг бүтээх арга зүйг сонгон ашиглана.
- Сургалтын материал, техник хэрэгсэл ашиглан (гарын авлага, лекцийн материал, видео бичлэг, кейс гэх мэт) сургалтыг аль болох шинэлэг арга зүйгээр зохион байгуулж, суралцагчдад хүргэнэ.
- Лекцийн арга, хэлэлцүүлэг, багаар ажиллах, асуудлын болон шийдлийн мод, эрэмбийн матрицын арга, картын арга, тохиолдол шинжлэх арга зэрэг идэвхтэй сургалтын арга, хэлбэрүүдээс ашиглана.
- Дасгал ажил болон үнэлгээнд ашиглах жишиг асуулт, ажлын хуудсуудыг ашиглана.

Үнэлгээ:

Сургалтын үнэлгээгээр сургалтын дараах хандлага, мэдлэг өөрчлөгдсөн эсэхийг тодорхойлно. Үнэлгээг сургалтын эхлэл, төгсгөлд асуулгын болон нээлттэй самбарын үнэлгээний аргаар авна.

1. Сэтгэл ханамж
 - Сургалтын явцад, эсвэл дараа нь санал асуултын хуудсаар оролцогчдын сэтгэл ханамжийн байдлыг үнэлнэ.
2. Мэдлэг эзэмшсэн байдал
 - Оролцогч сургалтын явцад заасан хичээлийн агуулгыг хэрхэн ойлгосон мөн өмнөх хичээлтэй харьцуулах, уялдуулах, дүгнэлт өгөх зэргийг үнэлнэ.
3. Хандлага, төлөвшил
 - Сургалтаар олж авсан мэдлэг, чадварыг бодитоор хэрэгжүүлэхэд хувь хүний бие даан болон багаар ажиллах чадвар, бусадтай харилцах харилцаа, хандлагын өөрчлөлт зэргийг ажиглалт, ярилцлага, бичгийн хэлбэрээр үнэлнэ.
4. Үр дүн
 - Оролцогч сургалтаар эзэмшсэн мэдлэг ур чадвараа бодит байдалд хэрэглэх чадвар, эрмэлзэл, сэдэл төрсөн тухай бичгийн /ажлын дэвтэрт бичих/ болон харилцан ярилцах, ажиглалт хийх хэлбэрээр үнэлнэ.
 - Сургалтын арга зүй зохион байгуулалтаас төрсөн сэтгэгдэлийг бичгээр болон онлайн тестээр авна.
 - Сургалтын явцад хийсэн SWOT шинжилгээ болон бусад бүтээлч багийн ажлуудын оролцоо, үр дүнгээр үнэлнэ.
 - Сургалтын дараа орон нутагтаа зохион байгуулсан сургалт, кампанит ажлуудыг зохион байгуулснаар үнэлнэ.

МОДУЛЬ 1.

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ИРГЭДИЙН ОРОЛЦООГ ХАНГАХ НЬ



МОДУЛЬ 1. АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ИРГЭДИЙН ОРОЛЦООГ ХАНГАХ НЬ

Модулийн товч танилцуулга:

Хичээлүүд	Хамрах сэдэв	Дасгал ажил	Дасгалын зорилго
Хичээл 1.1. Авлигатай тэмцэх үйл ажиллагаанд иргэдийн оролцоо, үр нөлөө 3 цаг	<ul style="list-style-type: none"> • Авлигатай тэмцэх үйл ажиллагаан дах иргэдийн оролцооны ач холбогдол, тэдгээрийн үзүүлэх нөлөө. • Авлигын эсрэг иргэдийн санаачилга, сайн туршлагууд 	Сэдэлжүүлэх дасгал:	Сэдэвтэй холбоотой нэр томъёо, ойлголтыг бататгах, сэдэлжүүлэх
		Иргэдийн оролцооны SWOT шинжилгээ	Оролцогчдод авлигатай тэмцэх үйл ажиллагаанд иргэдийн оролцооны үр нөлөөг шинжлэх, шаардлагатай мэдлэг, чадварыг хөгжүүлэх
Хичээл 1.2. Авлигатай тэмцэх үйл ажиллагаан дах иргэдийн цахим оролцоо 2 цаг	<ul style="list-style-type: none"> • Цахим оролцооны хэлбэрүүд • Олон нийтийн сүлжээгээр авлигыг мэдээлэх, хянах, сошиал медиагаар тэмцэх арга замууд. • 	Авлигын эсрэг цахим кампанит ажлын төлөвлөгөө боловсруулах дасгал	Оролцогчдыг авлигын эсрэг цахим кампанит ажил зохион байгуулах санаачилга гаргах, төлөвлөгөө боловсруулах аргад сургах, оролцогчдыг идэвхжүүлэх.
Хичээл 1.3. Авлигатай тэмцэх үйл ажиллагаан дах иргэдийн оролцооны бусад хэлбэрүүд 3 цаг	<ul style="list-style-type: none"> • Шүгэл үлээх буюу мэдээлэгчийн үүрэг • Олон нийтийн хяналт • Олон нийтийн хэлэлцүүлэг ба нийтийн сонсгол 	"Шүгэл үлээх буюу мэдээлэгчийн үүрэг" дасгал	Оролцогчдод шүгэл үлээгчийн үүргийн ач холбогдол, эрсдэл, хамгаалалтын талаар ойлголт өгч, тэднийг практик нөхцөлд сургах

Хичээл 1.1. Авлигатай тэмцэх үйл ажиллагаанд иргэдийн оролцооны ач холбогдол

Зорилго	Авлигатай тэмцэх үйл ажиллагаанд иргэдийн оролцоо, түүний ач холбогдол, нөлөөллийн талаар оролцогчдод мэдлэг олгох
Дэд сэдэв	<ul style="list-style-type: none">• Авлигатай тэмцэх үйл ажиллагаанд иргэдийн оролцооны ач холбогдол, тэдгээрийн үзүүлэх нөлөө.• Авлигын эсрэг иргэдийн санаачилга, сайн туршлагаууд
Зорилтот бүлэг	<ul style="list-style-type: none">• Иргэний нийгмийн сургагч багш нар
Зохион байгуулах алхмууд	<ul style="list-style-type: none">• Сэдэлжүүлэх дасгал ажил – 30 мин• Мэдлэг олгох – лекц – 60 мин• Мэдлэг бататгах дасгал – 60 мин• Сургалтын үнэлгээ-30 минут
Сургалтын эргэлгэдэхүүн	<ul style="list-style-type: none">• Хичээлийн слайд• Сургалтын техник: самбар, проектор, нотебүүк• Маркер, флипчарт, цаас, скоч

Сэдэлжүүлэх дасгал ажил:

Зорилго: Авлигатай холбоотой нэр томъёо, ойлголтуудыг бататгах, сэдэлжүүлэх
Аргачлал:

1. Оролцогчид 5 багт хуваарилагдан суусан байна. Танхимд 5 самбар байрлуулж, дугаарлан самбар тус бүрд нэг сэдвийг өнгийн цаасан дээр бичиж, тогтоосон байна.
2. Баг тус бүрд дээрх сэдвүүдэд хамаарах мэдэгдлүүдийг өнгө өнгийн картад бичиж тарааж өгнө.
3. Багууд карт дээрх мэдэгдлүүдийн утгыг ярилцаж, хамаарах самбарууд дээр байрлуулна.
4. Багууд өөрсдийн картуудыг байрлуулсны дараа өөрийн багийн дугаарт хамаарах самбар дахь нэр томъёог, оролцогчдын байрлуулсан мэдэгдлүүдийг ашиглан 5 минутад багтаан тайлбарлана.

Хамаарах нэр томъёо.

- Авлигын төрлүүд
- Авлига үүсэх шалтгаан
- Нийгэмд үзүүлэх нөлөө
- Авлигын эсрэг хууль тогтоомжууд
- Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн зорилтууд

Мэдлэг олгох лекцийн товч агуулга

Багш дараах товч агуулгын хүрээнд бэлтгэсэн танилцуулгыг ашиглан оролцогчдод мэдээлэл өгнө.

Сэдэв 1. Авлигатай тэмцэх үйл ажиллагаанд иргэдийн оролцооны ач холбогдол

Авлигатай тэмцэх үйл ажиллагаа нь зөвхөн төр засгийн үүрэг, хууль хяналтын байгууллагын ажил биш, харин бүх нийтийн хамтын оролцоог шаарддаг. Иргэдийн идэвхтэй оролцоо, тэдний дуу хоолой нь ил тод байдал, хариуцлагын тогтолцоог сайжруулах чухал хүчин зүйлсийн нэг юм.

Иргэдийн оролцоо нь олон нийтийн хяналтын гол эх үүсвэр бөгөөд төрийн байгууллага болон хувийн хэвшлийн ил тод байдал, хариуцлагыг нэмэгдүүлэхэд чухал үүрэгтэй. Авлигын эсрэг үйл ажиллагаанд иргэдийн оролцоог нэмэгдүүлснээр дараах ач холбогдолтой:

- **Ил тод байдлыг хангах:** Авлигатай тэмцэх үйл ажиллагаанд иргэдийн оролцоог идэвхжүүлснээр төрийн болон хувийн хэвшлийн үйл ажиллагаа ил тод, нээлттэй болно. Иргэд нь олон нийтийн мэдээллийн сувгуудаар дамжуулан төрийн байгууллагуудын үйл ажиллагааг хянах, санал өгөх, асуудал дэвшүүлэх боломжтой.
- Иргэдийн оролцоо нь төрийн болон хувийн хэвшлийн ил тод байдал, хариуцлагыг нэмэгдүүлэхэд чухал үүрэгтэй. Иргэдийн оролцоо нь олон нийтийн хяналтын эх үүсвэр болдог ба төрийн шийдвэр гаргалтад ил тод байдлыг нэмэгдүүлдэг гэж OECD судалгаагаар онцолсон байдаг¹. Мөн Transparency International байгууллагаас гаргасан судалгаагаар, иргэдийн мэдээлэл, оролцоотойгоор төрийн албан хаагчид илүү хариуцлагатай ажиллах боломжтой болохыг тодорхойлсон байна .
- **Мэдээлэл түгээх:** Иргэдийн оролцоо нь мэдээлэл түгээх болон авлигын талаар олон нийтэд мэдлэг олгоход чухал ач холбогдолтой байдаг бөгөөд энэ нь World Bank-ийн судалгаагаар батлагдсан байдаг² .
- **Хариуцлагыг нэмэгдүүлэх:** Иргэдийн хяналтын тусламжтайгаар төрийн албан хаагчид болон байгууллагууд илүү хариуцлагатай ажиллах шаардлагатай болдог. Иргэд нь өөрсдийн эрх ашгийг хамгаалах, төрийн байгууллага, албан хаагчийн буруутай үйл ажиллагааны талаар мэдээлэх, авлигын асуудалтай тэмцэхэд оролцох замаар хариуцлагын тогтолцоог нэмэгдүүлнэ.
- **Төрийн шийдвэрт нөлөөлөх:** Иргэдийн санал, мэдээлэл, оролцооны тусламжтайгаар төрийн шийдвэр гаргалтад нөлөөлөх боломж нэмэгддэг. Олон нийтийн оролцоо нь шийдвэр гаргахад ил тод байдал, үнэн зөв байдлыг хангах чухал хүчин зүйл юм.

Авлигын эсрэг тэмцэлд иргэдийн оролцоо дараах нөлөөллийг үзүүлдэг:

- **Авлигыг илрүүлэх:** Иргэдийн зүгээс авлигыг мэдээлэх үүрэг чухал бөгөөд ингэснээр авлигыг илрүүлдэд тэдний оролцоог нэмэгдүүлдэг байна. Иргэд авлигын талаар мэдээлэл гаргах суваг, аппликейшн, платформуудаар дамжуулан авлигын эсрэг үйл ажиллагаанд идэвхтэй оролцдог.
- **Авлигын талаар олон нийтэд мэдээлэл түгээх:** Иргэдийн оролцоотойгоор соён гэгээрүүлэх хөтөлбөрүүд хэрэгжүүлж, авлигын талаарх мэдлэгийг нэмэгдүүлж болно. Иргэдийн оролцоо нь зөвхөн төрийн хяналтыг сайжруулаад зогсохгүй, авлигын эсрэг мэдлэг, ухамсрыг олон нийтийн түвшинд өргөжүүлэхэд тусалдаг.
- **Хуулийн хэрэгжилтэд хяналт тавих:** Иргэд, иргэний нийгмийн байгууллагууд төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавьж, хуулийн хэрэгжилт, шударга ёсыг хангах чухал үүрэгтэй. Жишээ нь иргэдийн хяналтын бүлэг байгуулж,

¹ OECD (2018). “Engaging Citizens in Anti-Corruption Efforts: Practices and Emerging Trends.” <https://www.oecd.org>

² World Bank. “Empowering Citizens Against Corruption: A Resource Guide.” <https://www.worldbank.org>

нийтийн шийдвэр гаргалтад оролцох нь авлигын эсрэг үйл ажиллагааны үр нөлөөг нэмэгдүүлдэг.

Монгол Улсад “Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам”³-ын заалтыг баримтлан иргэд, иргэний нийгмийн байгууллагууд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх боломж нээлттэй байна. **Журамд зааснаар** төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг дор дурдсан чиглэлээр⁴ хэрэгжүүлэх боломжтой. Үүнд:

1. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд заасан мэдээллийн ил тод, нээлттэй байдал;
2. Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийн ил тод, нээлттэй байдал;
3. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2-т заасан иргэний эрх, мөн хуулийн 34, 36, 38, 39 дүгээр зүйлийн хэрэгжилт;
4. Авлигын эсрэг хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 6 дугаар зүйлийн 6.1-д заасан төрийн байгууллагын хүлээх нийтлэг үүргийн хэрэгжилт;
5. Захиргааны ерөнхий хуулийн 62 дугаар зүйлийн 62.1-д заасан саналыг авсан эсэх, мөн зүйлийн 62.2-т заасан хэлэлцүүлгийг хийсэн эсэх;
6. Төсвийн тухай хуульд заасан олон нийтийн оролцоог хангах, олон нийтийг хяналт тавих боломжоор хангасан эсэх;
7. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны журмын хэрэгжилтийн байдал;
8. Албан тушаалтан хандив авах, давхар ажил эрхлэх, төлбөр авах, төлөөлөл хэрэгжүүлэх зэрэг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан хориглолт, хязгаарлалтыг зөрчсөн эсэх;
9. Албаны үүргээ хэрэгжүүлэх явцад үл ойлгогдохуйц нөхцөл байдал үүсгэсэн, ашиг сонирхлын зөрчилтэй нөхцөл байдалд шийдвэр гаргасан, үйл ажиллагаа эрхэлсэн эсэх;
10. Годорхой салбарт болон орон нутаг, нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтнаас батлан мөрдүүлсэн шийдвэр нь дор дурдсан нөхцөл байдлыг үүсгэсэн эсэх:
 - 10.1.хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаагүй;
 - 10.2.ил тод, нээлттэй байдлыг хязгаарласан;
 - 10.3.ашиг хонжоо олох, давуу байдал үүсгэх боломж бүрдүүлсэн;
 - 10.4.үндэслэлгүй төлбөр хураамж тогтоосон;
 - 10.5.хуулиар хориглосон, хязгаарласан хэм хэмжээ тогтоосон эсэх;
 - 10.6.хууль тогтоомжоор зөвхөн тухайн албан тушаалтанд олгосон эрх хэмжээг бусдад шилжүүлсэн, боломж олгосон;
 - 10.7.хууль тогтоомж зөрчин аливаа бүтэц, нэгж, орон тоо, эрх хэмжээ бий болгосон эсэх;
 - 10.8.аливаа байгууллага, иргэн шударгаар өрсөлдөх боломжийг хязгаарласан, сонгон шалгаруулалтын зарчмыг алдагдуулсан эсэх;
 - 10.9.улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгийг үр дүнгүй зарцуулах нөхцөлийг бүрдүүлсэн;

³ Засгийн газрын 2021 оны 109 дүгээр тогтоолын хавсралт

⁴ “Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам. 2 дахь заалт

10.10.иргэд, олон нийтийн оролцоо, санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх, шийдвэрлэх явцын мэдээллээр хангагдах боломжийг хязгаарласан;

Сэдэв 2. Иргэдийн оролцооны жишээ, авлигын эсрэг иргэдийн санаачилга, сайн туршлагаууд

Олон улсын жишээ:

- **Бразилийн “Transparency Portal”:** Бразилийн засгийн газар авлигын эсрэг нээлттэй өгөгдлийн платформыг нэвтрүүлснээр иргэд төрийн зарцуулалтын талаар ил тод мэдээлэл авах боломжтой болсон. Энэ нь авлигын түвшнийг бууруулахад томоохон нөлөө үзүүлсэн.
- **Гана улсын “I Paid a Bribe” платформ:** Энэхүү платформ нь иргэдээс авлигын тухай мэдээлэл цуглуулж, авлигын хэлбэрийг баримтжуулах боломжийг бүрдүүлсэн.
- **Монгол Улсын жишээ:** Монгол Улсад авлигын эсрэг иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор иргэний нийгмийн байгууллагууд нийгмийн мониторингийн төслүүд хэрэгжүүлж байна. (Хавсралт 1. Төрийн худалдан авах үйл ажиллагаанд мониторинг хийсэн ТББ-уудын жишээ, үр дүн)

Иргэдийн оролцоог дэмжих арга замууд

- **Шүгэл үлээгчийг хамгаалах тогтолцоо:** Авлигын талаар мэдээлэл өгсөн иргэдийг хамгаалах эрх зүйн орчин бий болгох нь тэдний оролцоог нэмэгдүүлэхэд чухал үүрэгтэй.
- **Цахим засаглал ба дэвшилтэт технологиуд:** Технологийн дэвшилтэт шийдлүүд, цахим засаглалын платформууд нь иргэдийн оролцоог дэмжиж, авлигын хяналт, мэдээлэл гаргах үйл ажиллагааг хялбаршуулдаг.
- **Иргэдийн боловсрол:** Олон нийтийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, соён гэгээрүүлэх хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх замаар иргэдийн авлигын талаарх мэдлэгийг дээшлүүлж, авлигын эсрэг идэвхтэй оролцоо, хяналтыг дэмжих боломжтой.

Дүгнэлт

Авлигатай тэмцэх үйл ажиллагаанд иргэдийн оролцоо нь нийгэмд томоохон нөлөө үзүүлж, засаглалын ил тод байдал, хариуцлагыг нэмэгдүүлж, төрийн байгууллагуудын шударга байдлыг хангахад чухал үүрэгтэй. Иргэдийн идэвхтэй оролцоогоор авлигын эсрэг үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлж, шударга нийгмийг бий болгох боломжтой.

Мэдлэг бататгах дасгал ажил.

Дасгал ажлын зорилго:

- Иргэдийн оролцооны ач холбогдол, тэдгээрийн авлигын эсрэг үйл ажиллагаанд үзүүлэх нөлөөллийг SWOT (Strengths, Weaknesses, Opportunities, Threats) шинжилгээний аргаар тодорхойлох.
- Оролцогчдод авлигын эсрэг тэмцэх иргэдийн үүргийг гүнзгий ойлгуулах, асуудлыг олон талаас нь харж шинжлэх чадварыг хөгжүүлэх.

Дасгал ажлын заавар:

1. Багуудад хуваах:

- Оролцогчдыг 4-5 хүнтэй багуудад хуваана. Баг бүр өөрийн багийн дотор харилцан ярилцаж, SWOT шинжилгээг хамтран хийх боломжтой.

2. SWOT шинжилгээний бүтэц танилцуулах:

- **Давуу талууд (Strengths):** Иргэдийн оролцоо ямар давуу талтай вэ? Яагаад авлигын эсрэг тэмцэлд чухал гэж үзэж байна?
- **Сул талууд (Weaknesses):** Иргэдийн оролцоо ямар асуудалтай тулгарч болох вэ? Үр дүнг сааруулах хүчин зүйлүүд юу байж болох вэ?
- **Боломжууд (Opportunities):** Иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, сайжруулах боломжууд юу вэ? Ямар шинэ боломжууд бий болж байна вэ?
- **Аюул занал (Threats):** Иргэдийн оролцоог сулруулах аюулууд юу байж болох вэ? Гадны эсэргүүцэл, хязгаарлалт юу байж болох вэ?

3. Шинжилгээ хийх аргачлал:

Алхам 1. SWOT шинжилгээний хүснэгтийг бөглөх: Баг бүрт SWOT шинжилгээний хүснэгт өгнө (эсвэл өөрсдөө үүсгэнэ). Хүснэгтэнд дээр дурдсан дөрвөн элемент бүрт тохирох өгөгдлүүдийг бичнэ.

Давуу талууд (Strengths)	Сул талууд (Weaknesses)
Боломжууд (Opportunities)	Аюул занал (Threats)

Алхам 2: Ярилцах, санал солилцох: Багийн гишүүд SWOT шинжилгээг бие даан боловсруулж, дүгнэлтээ бусадтайгаа хуваалцаж ярилцана. Хариулт бүрийг баталгаажуулах, илүү тодорхой мэдээлэл оруулахыг зорьж, харилцан ярилцах.

Алхам 3: Шийдэл гаргах: SWOT шинжилгээнд тулгуурлан баг бүр иргэдийн оролцоог хэрхэн нэмэгдүүлж, сул тал, аюулаас урьдчилан сэргийлэх талаар бодит шийдлүүд гаргана.

4. Багуудын дүгнэлт, танилцуулга:

- Баг бүр SWOT шинжилгээний үр дүн, багийн дүгнэлтээ танилцуулна. Дүгнэлтэд SWOT шинжилгээнээс гарсан гол санаанууд, иргэдийн оролцоог сайжруулах арга замуудыг багтаасан байна.
- Оролцогчид багуудын танилцуулгыг сонсож, харилцан санал солилцож, хэлэлцүүлэг өрнүүлнэ.

Оролцогчдод өгөх зөвлөмжүүд:

1. **Идэвхтэй оролцох:** Багийнхаа дотор харилцан яриа өрнүүлж, SWOT шинжилгээнд оролцогч бүрийн санаа бодлыг сонсож, тусгах.
2. **Шударга, бодитой шинжилгээ хийх:** Иргэдийн оролцоонд нөлөөлж буй хүчин зүйлүүдийг үнэн зөв, бодитойгоор шинжлэх.
3. **Тодорхой дүгнэлт гаргах:** SWOT шинжилгээнээс гарсан үр дүнг бодитой, үр дүнтэй шийдлүүд болгон хувиргахыг зорих.
4. **Харилцан ярилцах:** Хамтран ажиллаж, олон талт үзэл бодлыг хүндэтгэн, илүү өргөн хүрээтэй дүгнэлт гаргах.

Сургалтын үнэлгээ:

- Оролцогчдын дунд сургалтыг дүгнэсэн ярилцлага өрнүүлж, өөрсдөөр нь үнэлүүлнэ.

Ашиглах материал:

1. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр.
2. Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам. (Засгийн газрын 2021 оны 109 дүгээр тогтоолын хавсралт)
3. Авлигатай тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилт, авлигын ерөнхий нөхцөл байдал 2023. АТГ, Улаанбаатар 2024 он.
4. Авлигатай тэмцэх үйл ажиллагаа дэлхий дахинд. АТГ. Улаанбаатар 2022 он.
5. АТГ-аас зохион байгуулж буй олон нийттэй харилцах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны үр дүн, ач холбогдлын талаарх олон нийтийн санаа бодлын судалгааны тайлан, зөвлөмж. УБ.2020 он. Төрийн бодлогын шинжилгээний хүрээлэн
6. Авлигын талаарх олон нийтийн ойлголт мэдлэг тогтоох судалгаа. 2018 он.
7. “Авлигын эсрэг үндэсний чуулган-2021” илтгэлүүдийн эмхэтгэл
8. Авлигын төсөөллийн индекс. Товхимлууд
<https://www.transparency.org/en/cpi/2020/results>
9. [HTTPS://IAAC.MN/POST/159399](https://iaac.mn/post/159399) Авлигатай тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилт, авлигын ерөнхий нөхцөл байдал, авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт 2022
10. Transparency International. “The Role of Civil Society in Combating Corruption.”
<https://www.transparency.org>
11. OECD (2018). “Engaging Citizens in Anti-Corruption Efforts: Practices and Emerging Trends.”
<https://www.oecd.org>
12. World Bank. “Empowering Citizens Against Corruption: A Resource Guide.”
<https://www.worldbank.org>
13. Heimann, F. (2011). *Confronting Corruption: The Elements of a National Integrity System*

Хичээл 1.2. Авлигатай тэмцэх үйл ажиллагаан дах иргэдийн цахим оролцоо

Зорилго	Авлигатай тэмцэх иргэдийн цахим оролцооны ач холбогдол, боломжуудын талаар оролцогчдод ойлголт өгөх, авлигын эсрэг цахим оролцоог нэмэгдүүлэх боломжийн талаар мэдлэг олгох.
Зорилтот бүлэг	Иргэний нийгмийн сургагч багш нар
Дэд сэдвүүд	<ul style="list-style-type: none">• Цахим оролцооны хэлбэрүүд, цахим оролцооны үр нөлөө• Цахим оролцоог нэмэгдүүлэх арга замууд
Зохион байгуулах алхмууд	<ul style="list-style-type: none">• Сэдэлжүүлэх дасгал ажил – 30 мин• Мэдлэг олгох – лекц – 40 мин• Мэдлэг бататгах дасгал – 30 мин• Сургалтын үнэлгээ - 20 мин
Сургалтын хэрэглэгдэхүүн	<ul style="list-style-type: none">• Хичээлийн слайд• Сургалтын техник: самбар, проектор, нотебүүк• Маркер, флипчарт, цаас, скоч

Сургагч багшид зориулсан зөвлөгөө

Мэдлэг олгох лекцийн товч агуулга

Сэдэв 1. Цахим оролцооны хэлбэрүүд, цахим оролцооны үр нөлөө

“Иргэний цахим оролцоо” гэдэг нь иргэд технологийн тусламжтайгаар төр засгийн үйл ажиллагаанд оролцох үйл явц юм. Үүнд олон нийтийн санал асуулга, онлайн хэлэлцүүлэг, сошиал медиагаар мэдээлэл түгээх зэрэг хэлбэрүүд багтана. Жишээлбэл Төрийн худалдан авалтын мэдээллийг цахим системд ил тод байршуулснаар иргэд хяналт тавих боломжтой болж байгаа нь үйл ажиллагаа нь авлигаас урьдчилан сэргийлэх нэг арга хэлбэр юм.

Цахим платформууд, сошиал медиа, мэдээлэл түгээх хэрэгслүүд нь авлигын эсрэг хяналт, мэдээлэл өгөлт, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх боломжийг хэрхэн бүрдүүлж байгааг тодорхойлохыг зорьдог. Цахим орчин дахь оролцоо нь мэдээллийг хурдан түгээх, олон нийтэд хяналт тавих, төрийн байгууллагуудын ил тод байдалд нөлөөлөх хүчирхэг хэрэгсэл болдог.

Хамгийн их ашиглагддаг цахим платформууд нь Twitter, Facebook зэрэг сошиал медиагийн платформууд бөгөөд эдгээрийг ашиглан авлигын мэдээллийг илрүүлэх, хэлэлцүүлэг өрнүүлэх боломжтой. Мөн түүнчлэн шүгэл үлээхэд зориулсан Transparency International, UNCAC Coalition зэрэг байгууллагуудын цахим хэрэгслүүд нь авлигын талаар мэдээлэл өгөх, хамгаалах тал дээр улс орнуудад ихээхэн дэмжлэгтэй байна.

Сошиал медиа болон мэдээлэл өгөх платформуудын үүрэг:

- **Сошиал медиа:** Иргэдийн дуу хоолойг хүчирхэгжүүлж, авлигын эсрэг тэмцэлд шууд оролцох боломжийг бий болгодог. Twitter, Facebook, YouTube зэрэг платформууд нь авлигын үйл явдлыг мэдээлэх, хэлэлцүүлэг өрнүүлэх хүчирхэг хэрэгсэл болж байна.

- **Цахим шүгэл үлээх платформууд:** Иргэдээс авлигын мэдээлэл цуглуулах, нууцлалтай мэдээлэл өгөх цахим платформууд нь авлигын эсрэг тэмцэлд онцгой үүрэгтэй. **Жишээ:** "I Paid a Bribe" зэрэг платформууд нь иргэдийн өгсөн мэдээллийг ашиглан авлигын хэлбэрийг баримтжуулж, олон нийтэд хүргэдэг.

Цахим оролцооны хэлбэрүүд

- **Онлайн санал асуулга, хэлэлцүүлэг:** Цахим платформуудын тусламжтайгаар иргэд олон нийтийн хэлэлцүүлэгт оролцож, шийдвэр гаргахад шууд нөлөөлж чадна. Төрийн бодлого, хуулийн төсөл дээр санал өгөх боломжийг цахим оролцоо бүрдүүлдэг.
- **Авлигын талаар мэдээлэл өгөх платформууд:** Технологийн дэвшил ашиглан авлигын талаарх мэдээллийг шүгэл үлээгчийн системээр дамжуулан нууцлалтайгаар өгөх боломжтой болсон. Энэ нь цахим платформын авлигын эсрэг үр дүнтэй ашиглах нэг хэлбэр юм.

Цахим оролцооны хэрэгслийн ашиг тус:

- **Нээлттэй өгөгдөл:** Төрийн байгууллагуудын үйл ажиллагааг цахим орчинд ил тод болгох замаар иргэдийн хяналт, оролцоог нэмэгдүүлдэг.
- **Бодит цагийн мэдээлэл:** Цахим платформууд нь авлигын асуудалд хурдан хариу өгөх, мэдээллийг шуурхай тараахад тустай.

Сошиал медиа, цахим оролцооны үр нөлөө

- **Олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх:** Цахим платформууд болон сошиал медиа нь олон нийтийн оролцоог өргөжүүлэх, олон нийтийн мэдээлэл авах боломжийг нэмэгдүүлдэг.
- **Ил тод байдал:** Сошиал медиа нь төрийн байгууллагуудын үйл ажиллагааг ил тод байлгах, иргэдийн итгэлийг нэмэгдүүлэхэд тусалдаг.
- **Нийгмийн кампанит ажилд дэмжлэг үзүүлэх:** Сошиал медиагийн тусламжтайгаар олон нийтийн авлигын эсрэг хөдөлгөөн, кампанит ажлыг өргөн хүрээнд зохион байгуулах боломжтой.
- **Олон нийтийн кампанит ажил ба цахим оролцоо:** Цахим кампанит ажил, олон нийтийн хөдөлгөөнийг сошиал медиад хэрхэн зохион байгуулах, үр дүнтэй байдлыг хангах талаар мэдээлэл өгөх.

Мэдээллийг түгээх боломжууд

- **Сошиал медиад нийтлэл бичих:** Иргэд болон хэвлэл мэдээллийн байгууллагууд авлигын асуудлыг олон нийтэд ил болгож, сошиал медиа платформуудад шуурхай нийтэлж болно. Мэдээллийг ил болгосноор төрийн байгууллагууд хариуцлага хүлээх боломж нэмэгддэг.
- **Видео, зураг ашиглах:** Видео, зураг зэрэг аудио-визуал материалыг ашиглан авлигын үйл явдлыг баримтжуулж, олон нийтэд түгээх нь авлигын талаар хурдан мэдээлэл өгөх үр дүнтэй арга юм.
- **Жишээ:** Twitter дээр авлигын талаар хаштаг ашиглан мэдээлэл түгээж, олон нийтийн анхаарлыг татах.

Сэдэв 2. Авлигын эсрэг цахим оролцоог нэмэгдүүлэх арга замууд

Авлигын эсрэг иргэдийн цахим оролцоог нэмэгдүүлэх нь авлигын эсрэг тэмцэлд ил тод байдлыг хангах, хариуцлагыг нэмэгдүүлэх, иргэдийн оролцоог дэмжих чухал арга зам юм. Цахим оролцоо нь хүмүүсийг мэдээлэлтэй болгох, тэдэнд хяналт тавих боломж олгох, шуурхай мэдээлэл өгөх замаар авлигыг бууруулахад хувь нэмэр оруулдаг.

Иргэдийн цахим оролцоог нэмэгдүүлэх үндсэн арга замууд

1. **Цахим мэдээлэл түгээх платформууд:**
 - Засгийн газар, төрийн байгууллагуудын мэдээллийг иргэдэд хүргэх цахим платформуудыг хөгжүүлэх нь иргэдийн цахим оролцоог дэмждэг. Жишээ нь, төсвийн зарцуулалт, худалдан авалтын үйл явцын мэдээллийг ил тод болгох.
 - Иргэдэд шаардлагатай мэдээллийг ойлгомжтой хэлбэрээр үзүүлэх цахим хэрэгслүүдийг (дашбоард, инфографик) хөгжүүлэх.
2. **Сошиал медиагийн хяналт, оролцоо:**
 - Сошиал медиа платформуудыг ашиглан авлигын эсрэг кампанит ажлыг өрнүүлэх нь иргэдийн анхаарлыг татаж, авлигын эсрэг үйл ажиллагаанд оролцох боломжийг олгоно.
 - Авлигын эсрэг мэдээлэл, мэдлэгийг цахим орчинд түгээх, хэлэлцүүлэг өрнүүлэх, мэдээлэл хуваалцах нь олон нийтийн оролцоог нэмэгдүүлэхэд тустай.
3. **Цахим санал асуулга, хэлэлцүүлэг:**
 - Иргэдийн дунд цахим хэлэлцүүлэг зохион байгуулах, санал асуулга явуулах замаар тэдний үзэл бодлыг авах боломжтой.
 - Цахим хэлэлцүүлгүүдийг асуудалд хариу өгөх, шийдэл боловсруулах үйл явцад иргэдийн оролцоог хангахад ашиглах.
4. **Шүгэл үлээх цахим платформууд:**
 - Иргэд авлигын талаар мэдээлэх, мэдээллийг нууцлалтайгаар дамжуулах боломжтой цахим шүгэл үлээх системүүдийг ашиглах боломжийг олгох. Жишээ нь, Transparency International-ийн шүгэл үлээх платформууд.
 - Цахим мэдээлэл өгөх хэрэгсэл нь иргэдийг авлигын эсрэг тэмцэлд оролцуулах, хариуцлагыг нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулна.
5. **Нээлттэй өгөгдлийн систем:**
 - Төрийн байгууллагуудын мэдээллийг нээлттэй өгөгдлийн хэлбэрээр олон нийтэд түгээх нь иргэдийн оролцоог нэмэгдүүлдэг. Энэ нь төсвийн зарцуулалт, худалдан авалт, тендерийн үйл явцын мэдээллийг хянах боломжийг олгодог.
 - Нээлттэй өгөгдөл ашиглан иргэд төрийн үйл ажиллагаанд хяналт тавьж, ил тод байдлыг баталгаажуулдаг.
6. **Авлигын талаар мэдээлэл өгөх контент:**
 - Авлигатай тэмцэх үйл ажиллагаанд оролцохыг дэмжих цахим контент (видео, блог, подкаст гэх мэт) бүтээж, цахим платформуудаар дамжуулан түгээх.
 - Авлигын талаарх цахим сургалт, видео хичээлээр дамжуулан иргэдийг мэдээлэлтэй болгож, тэднийг идэвхжүүлэх.

Иргэдийн цахим оролцоог нэмэгдүүлэхийн ач холбогдол

- **Ил тод байдал, хариуцлага:** Цахим оролцоо нь төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг нэмэгдүүлж, хариуцлагыг дээшлүүлэхэд тустай.
- **Иргэдийн дуу хоолойг төрд хүргэх:** Цахим хэлбэрээр иргэдийн үзэл бодлыг хүлээн авч, тэдний санал хүсэлтийг төрийн бодлогод тусгах боломжтой.

- **Авлигын илрүүлэлт, мэдээлэл дамжуулалт:** Цахим платформуудыг ашиглан иргэд авлигын талаар мэдээлэл дамжуулж, хууль бус үйл ажиллагааг илрүүлэхэд хувь нэмэр оруулах боломжтой.

Авлигын эсрэг иргэдийн цахим оролцоог нэмэгдүүлэх нь авлигын эсрэг тэмцэлд олон нийтийн оролцоог өргөжүүлж, ил тод байдал, хариуцлагыг сайжруулахад чухал ач холбогдолтой. Цахим хэрэгслүүдийг үр дүнтэй ашигласнаар иргэд төрийн үйл ажиллагаанд хяналт тавих, мэдээлэл өгөх боломжтой болж, авлигын эсрэг тэмцлийг бодитой үр дүнтэй болгоход дэмжлэг үзүүлнэ.

Мэдлэг бататгах дасгал ажил:

Авлигын эсрэг цахим кампанит ажлын төлөвлөгөө боловсруулах дасгал.

Дасгалын зорилго: Оролцогчдыг авлигын эсрэг цахим кампанит ажил зохион байгуулах санаачилга гаргах, төлөвлөгөө боловсруулах аргад сургах, оролцогчдыг идэвхжүүлэх.

Аргачлал: Оролцогчдыг 3-5 багт хуваана. Дээр өгсөн мэдээлэл, аргачлалыг ашиглан багууд авлигын эсрэг социал медиа ажлын төлөвлөгөө гаргаж, агуулгыг танилцуулах даалгавар өгнө. Жишээ нь:

- Twitter дээр #АвлигынЭсрэг хаштагтай мэдээлэл түгээх,
- Facebook групп үүсгэх зэрэг арга хэмжээ зохион байгуулах,
- "Төрийн ил тод байдлыг дэмжицгээе" гэсэн уриатай кампанит ажлыг зохион байгуулж, олон нийтийг социал медиад татан оролцуулах төлөвлөгөө боловсруулна.

Багууд өөрсдийн зохион байгуулах ажлын төлөвлөгөөг цаасан самбарт буулгаж, сургалтын хэрэглэгдэхүүнийг ашиглан зурах, наах, бичих зэрэг хэлбэрээр танилцуулна.

Сургалтын үнэлгээ:

- Багуудын хийсэн цахим оролцоог нэмэгдүүлэх ажлын төлөвлөгөөгөөр сургалтыг үнэлнэ.
- Үнэлгээний багийг дасгал ажил эхлэхийн өмнө оролцогчдоос 3 гишүүн бүхий баг томилж зохион байгуулна.

Ашиглах материал:

1. Transparency International (TI) - "Anti-Corruption Campaigns"

- TI нь авлигын эсрэг олон улсын шилдэг туршлагаудыг хуваалцаж, олон нийтийг цахим болон оффлайн орчинд авлигын эсрэг кампанит ажил зохион байгуулахад чиглүүлдэг. Тэдний цахим кампанит ажлуудын талаар судалж, жишээнүүдтэй танилцаж болно.

2. United Nations Office on Drugs and Crime (UNODC) - Anti-Corruption Education Materials

- UNODC-ийн боловсруулсан сургалтын материалыг ашиглан авлигын эсрэг цахим кампанит ажил зохион байгуулах арга зүй, цахим оролцоог дэмжих технологийн талаар мэдээлэл авч болно.

3. I Paid a Bribe (Janaagraha)⁵

- **"I Paid a Bribe"** нь Энэтхэгт эхэлсэн иргэдийн шүгэл үлээх платформ бөгөөд авлигын мэдээллийг цахим орчинд цуглуулж, түгээх зорилготой. Авлигын эсрэг цахим оролцооны тодорхой жишээнүүдийг судлах боломжтой.

4. OECD - "Public Sector Integrity through Citizen Engagement"⁶

- OECD-ийн энэ тайлан нь авлигын эсрэг цахим оролцооны ач холбогдлыг онцолж, олон нийтийг кампанит ажилд татан оролцуулах талаар мэдээлэл өгдөг. Төрийн ил тод байдал, цахим хяналтын тухай судлахад тохиромжтой материал.

5. World Bank - "ICT in Anti-Corruption Efforts"

- Дэлхийн банкнаас гаргасан энэхүү тайлан нь технологийг ашиглан авлигын эсрэг цахим кампанит ажил, цахим оролцоог хэрхэн дэмжих талаар гүнзгий судалгаа өгдөг. Иргэдийн цахим оролцоог нэмэгдүүлэхэд шаардлагатай технологийн шийдлүүдийг онцолдог. [World Bank ICT and Anti-Corruption](#)

6. UNCAC Coalition - "Whistleblower Protection and Online Reporting Mechanisms"

- Авлигын эсрэг олон улсын хуулийн хэрэгжилтийг хянах UNCAC Coalition-ийн вэбсайтаас шүгэл үлээгчдийн цахим хамгаалалт, мэдээлэл өгөх платформуудын талаар мэдээлэл авч, цахим орчинд хэрхэн тэмцэх талаар мэдлэгээ өргөжүүлж болно. [UNCAC Coalition Whistleblower Resources](#)

7. Social Media Campaign Resources - Hootsuite & Buffer

- Сошиал медиаг ашиглан авлигын эсрэг кампанит ажил явуулахад зориулсан стратеги, контент хөгжүүлэх зөвлөмжүүдийг Hootsuite болон Buffer зэрэг сошиал медиа удирдлагын хэрэгслүүдийн блог, вэбсайтуудаас судалж болно.
 - Hootsuite Social Media Campaigns
 - Buffer Social Media Resources

⁵ [I Paid a Bribe Website](#)

⁶ [OECD Integrity Report](#)

Хичээл 1.3. Авлигатай тэмцэх иргэдийн оролцооны бусад хэлбэрүүд

Зорилго	Авлигатай тэмцэх иргэдийн оролцооны бусад хэлбэрүүдийг танилцуулж, оролцогчдын мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх,
Зорилтот бүлэг	<ul style="list-style-type: none">• Иргэний нийгмийн сургагч багш нар
Дэд сэдвүүд	<ul style="list-style-type: none">• Шүгэл үлээх буюу мэдээлэгчийн үүрэг• Олон нийтийн хяналт• Олон нийтийн хэлэлцүүлэг ба нийтийн сонголт
Зохион байгуулах алхмууд	<ul style="list-style-type: none">• Сэдэлжүүлэх дасгал ажил – 30 мин• Мэдлэг олгох – лекц – 60 мин• Мэдлэг бататгах дасгал – 60 мин• Сургалтын үнэлгээ - 30 мин
Сургалтын хэрэглэгдэхүүн	<ul style="list-style-type: none">• Хичээлийн слайд• Сургалтын техник: самбар, проектор, нотебүүк• Маркер, флипчарт, цаас, скоч

Сургагч багшид зориулсан зөвлөгөө

Авлигатай тэмцэх үйл ажиллагааны хүрээнд шүгэл үлээгчийг хамгаалах эрх зүйн орчныг бүрдүүлснээр гарах эерэг нөхцөл, байдлын талаар ойлголт өгөхөд анхаарлаа хандуулна.

Оролцогчдод шүгэл үлээгчийн бодит жишээнүүд дээр дүн шинжилгээ хийх, тэдний үүрэг, эрсдэл, авлигын эсрэг тэмцэлд үзүүлэх нөлөөг ойлгуулахад дасгал ажлыг чиглүүлнэ.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 10 дугаар зүйлийн заалтыг тусгайлан бэлтгэж, оролцогчдод тарааж өгнө.

Сэдэлжүүлэх дасгал ажил

“Тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагад шүгэл үлээгчийг хамгаалах эрх зүйн орчин, хэрэгцээ шаардлага” хэлэлцүүлгийн видео бичлэгийг үзүүлж, ярилцана. <https://youtu.be/qE-VtVx6S-U?t=48>

Мэдлэг олгох лекцийн товч агуулга:

Авлигатай тэмцэх иргэдийн оролцооны бусад хэлбэрүүд: Иргэдийн оролцоо олон хэлбэрээр илэрч болох ба тэдгээр нь авлигын түвшнийг бууруулах, авлигын ил тод байдлыг нэмэгдүүлэхэд чиглэнэ.

Авлигатай тэмцэх үйл ажиллагаанд иргэний оролцооны дараах үндсэн хэлбэрүүд байна.

Сэдэв 1. Шүгэл үлээх буюу мэдээлэгч: Иргэд хууль бус үйл ажиллагаа, авлигыг мэдээлэх замаар оролцдог. Шүгэл үлээх нь авлигыг илрүүлж, мэдээлэгчдийг хамгаалах тусгай системээр дамжуулан хэрэгждэг чухал арга юм. Нөгөө талаас хууль бус үйлдэл, авлига, эсвэл ёс зүйн зөрчилтэй холбоотой асуудлыг дотоод байгууллага, олон нийтийн эсвэл хууль сахиулах байгууллагуудад мэдээлэх үйл явц юм. Мэдээлэгч нь ихэвчлэн тухайн үйл явдалд шууд оролцдог эсвэл түүнтэй холбоотой мэдээлэлтэй хүн байдаг бөгөөд тухайн асуудлын талаар нийгмийн ашиг сонирхлыг хамгаалах зорилготойгоор мэдээлэл өгдөг.

Шүгэл үлээгчид авлига, эрх мэдлээ урвуулан ашиглах зэрэг хууль бус үйлдлүүдийг илрүүлэх, олон нийтэд мэдээлэхэд чухал үүрэгтэй. Тэдний өгсөн мэдээлэл нь төрийн байгууллагуудын хууль бус үйл ажиллагааг илрүүлж, зохих хариуцлага хүлээлгэхэд тусалдаг. Жишээ нь, **Швейцарийн банкны шүгэл үлээгч Брэдли Биркенфельд** дэлхийн

банкны нууцлалын системийг илчилснээр АНУ-ын иргэдийн хууль бус гүйлгээг илрүүлж, татварын хуулийг сайжруулахад чухал үүрэг гүйцэтгэсэн. [UNODC](#)

Шүгэл үлээгчдийн эрхийг хамгаалах нь тэдний үүргийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд чухал үүрэгтэй. Олон улсад авлигын эсрэг хууль тогтоомж, дүрэм журмууд шүгэл үлээгчдийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авдаг. Үүний жишээ нь **UNCAC-ийн хүрээнд шүгэл үлээгчдийг хамгаалах механизм** юм. [UNODC](#)

Монгол Улсын Засгийн газраас таван бүлэг, 22 зүйл бүхий Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай анхдагч хуулийн төслийг 2021 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн байдаг. Энэ хуулийн зорилт нь нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээх нөхцөлийг бүрдүүлэх, шүгэл үлээгчийг дэмжих, хамгаалах, урамшуулах, түүний эрх зүйн байдлыг дордуулсан шинжтэй аливаа үйлдлээс урьдчилан сэргийлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахаар уг хуулийн төсөлд хуулийн зорилтыг тодорхойлжээ..

Монгол Улсын Үндсэн хууль⁷, Авлигын эсрэг хууль⁸, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль⁹, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль¹⁰, Гэрч хохирогчийг хамгаалах тухай¹¹ хуулийн зарим заалтууд нь иргэн, албан тушаалтан авлигын асуудлаар мэдээлэх, шүгэл үлээх эрх зүйн үндсийг нээж өгсөн байдаг.

Сэдэв 2. Авлигын эсрэг олон нийтийн хяналт

Авлигын эсрэг олон нийтийн хяналт нь иргэдийн оролцоотойгоор төрийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих, ил тод байлгах, төрийн хариуцлагыг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ юм. Энэ төрлийн хяналт нь Засгийн газар болон төрийн албан хаагчдын үйл ажиллагааг шударга, хууль ёсны дагуу хэрэгжүүлэхэд иргэдийн шууд оролцоог хангаж өгдөг бөгөөд авлигаас урьдчилан сэргийлэх, илрүүлэх, зогсооход чухал үүрэг гүйцэтгэдэг.

Олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх арга замуудад дээр дурьдсан шүгэл үлээх, цахим хяналт зэрэг арга хэлбэрүүд орохоос гадна **олон нийтийн хэлэлцүүлэг ба нийтийн сонсгол** орно. Эдгээр нь иргэд өөрсдийн саналыг тусгаж, төрийн бодлого шийдвэр гаргах үйл явцад оролцдог хэлбэрүүд юм.

Олон нийтийн хяналтын ач холбогдол:

- **Авлигын эрсдэлийг бууруулдаг.** Ил тод байдал, хяналттай орчин нь авлигын үйл ажиллагааг илрүүлэх, бууруулахад чухал үүрэгтэй.
- **Ил тод байдал:** Төрийн үйл ажиллагаа, төсөв, шийдвэр гаргалт, худалдан авалт зэрэг мэдээлэл олон нийтэд нээлттэй байснаар иргэд хяналт тавих боломжтой болно.
- **Төрийн байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлдөг.** Иргэд олон нийтийн зүгээс хяналт тавих замаар төрийн байгууллагууд илүү хариуцлагатай, ил тод байх нөхцөлийг бүрдүүлдэг. Төрийн албан хаагчдын үйл ажиллагаа болон шийдвэр гаргалтыг иргэд хянаснаар, тэдний хариуцлагатай байх нөхцөлийг бүрдүүлдэг.

⁷ “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 1992 оны 1 дүгээрт нийтлэгдсэн

⁸ “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2006 оны 35 дугаарт нийтлэгдсэн

⁹ “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2019 оны 42 дугаарт нийтлэгдсэн

¹⁰ “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2012 оны 8 дугаарт нийтлэгдсэн.

¹¹ “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2013 оны 30 дугаарт нийтлэгдсэн

- **Төрд итгэх иргэдийн итгэлийг нэмэгдүүлдэг.** Төрийн үйл ажиллагаанд иргэдийн хяналтыг хэрэгжүүлж, иргэд өөрсдөө оролцсноор төрийн байгууллагуудад итгэх иргэдийн итгэл нэмэгдэнэ.

Олон нийтийн хяналт нь зөвхөн төрийн байгууллагын үйл ажиллагаанд хязгаарлагдахгүй. Иргэд хувийн хэвшлийн байгууллагууд, иргэний нийгмийн салбарт ч хяналт тавих боломжтой байдаг.

Сэдэв 3. Олон нийтийн хэлэлцүүлэг ба нийтийн сонсгол: Иргэд бодлогын шийдвэр гаргах үйл явцад шууд оролцож, санал бодлоо илэрхийлэх хэлбэр бөгөөд иргэдийн санал нь төрийн байгууллагуудад шууд хүрч, авлигын эсрэг бодлогод нөлөөлдөг. Олон нийтийн зөвлөлдөөн ба сонсгол нь ардчилсан нийгэмд иргэдийн дуу хоолойг шийдвэр гаргах үйл явцад тусгах, төр засгийн үйл ажиллагааны ил тод байдал, хариуцлагыг дээшлүүлэх чухал арга хэрэгсэл юм.

Олон нийтийн хэлэлцүүлэг гэдэг нь тодорхой асуудлаар иргэд, төрийн болон хувийн байгууллагуудын оролцогчдын хооронд харилцан ярилцаж, санал солилцох үйл явц юм. Энэ нь аливаа бодлого, төсөл, хууль тогтоомж, олон нийтийн ач холбогдол бүхий асуудлуудыг шийдвэрлэхэд иргэдийн дуу хоолойг тусгахад чиглэдэг бөгөөд олон нийтийн санал бодлыг тусгах, нийгмийн оролцоог дэмжих, төрийн байгууллагын шийдвэр гаргахад иргэдийн оролцоог хангах зорилготой.

Энэ үйл явцад иргэдээс гадна төрийн албан хаагчид, иргэний нийгмийн байгууллагууд, хувийн хэвшлийн төлөөлөл оролцож, нийгмийн асуудлыг хамтран хэлэлцдэг.

Зөвлөлдөөнөөр бодлогын асуудал, хууль тогтоомжийн төсөл, төсвийн төлөвлөгөө зэрэг томоохон шийдвэр гаргахад иргэдийн дуу хоолойг хүргэх боломжтой. Энэ нь засаглалын ил тод байдал, иргэдийн итгэлийг нэмэгдүүлдэг. **Жишээ:** Хөгжлийн томоохон төслүүд дээр иргэдийн саналыг тусгах зорилгоор олон нийтийн зөвлөлдөөн зохион байгуулах.

Харин нийтийн сонсгол гэдэг нь иргэдийн санал бодлыг сонсох зорилгоор **төрийн байгууллагууд** зохион байгуулдаг албан ёсны арга хэмжээ юм. Олон нийтийн сонсголд иргэд, иргэний нийгмийн байгууллагууд, мэргэжлийн холбоод болон бусад сонирхсон бүлгүүд оролцож, асуудлыг ил тод байдлаар хэлэлцдэг. Энэ нь төрийн бодлого, төсвийн төлөвлөгөө, хууль тогтоомжийн төслүүдийн талаар иргэдийн санал хүсэлтийг хүлээн авах, шийдвэр гаргахад тусалдаг. **Жишээ** нь орон нутгийн төсвийн хуваарилалт, хот төлөвлөлтийн асуудлаар нийтийн сонсгол зохион байгуулдаг олон туршлагыг дурдаж болно.

Мэдлэг бататгах дасгал ажил

Шүгэл үлээх буюу мэдээлэгчийн үүрэг:

Аргачлал:

1. Оролцогчдыг багт хуваана.
2. Баг бүрт шүгэл үлээсэн бодит жишээнүүдийг тараан өгч, тэдгээрт дүн шинжилгээ хийх даалгавар өгнө.
3. Оролцогчид шүгэл үлээгчдийн хамгаалалт, тэдний үүрэг, авлигын эсрэг тэмцэлд үзүүлэх нөлөө, зөрчилдөөнүүдийн талаар дүгнэлт гаргана.
4. Гишүүдийн гаргасан дүгнэлтийг баг тус бүр танилцуулна.

Жишээ: Брадли Биркенфельд буюу Швейцарийн банкны шүгэл үлээгчийн кейс. Тэрбээр хууль бус татварын үйл ажиллагааны талаар мэдээлэл өгснөөр асар их хэмжээний торгууль оноогдож, АНУ-ын татварын хуулийг сайжруулахад нөлөөлсөн.

Сургалтын үнэлгээ

Үнэлгээний тест: Оролцогчдын мэдлэг ойлголтыг тандах зорилгоор хичээлийн эхэнд ба төгсгөлд 10 асуулт бүхий тест бөглүүлж, ахиц, өөрчлөлтийг дүгнэнэ.

Ашиглах материал

1. Шүлэг үлээгчийг хамгаалах хууль нь авлигатай тэмцэх том алхам. Ярилцлага.
<https://gogo.mn/r/wjkm>

МОДУЛЬ 2.

АВЛИГЫН ЭСРЭГ ИРГЭДИЙН ХЯНАЛТЫН МЕХАНИЗМ



МОДУЛЬ 2. АВЛИГЫН ЭСРЭГ ИРГЭДИЙН ХЯНАЛТЫН МЕХАНИЗМ

Модулийн товч танилцуулга:

Зорилго: Иргэдийн зүгээс байгууллага, төрийн алба, бизнесийн салбарын үйл ажиллагаанд хяналт тавих боломжийг олгодог иргэдийн хяналтын бүлэг, бүтэц, механизмын талаар танилцуулах

Хичээлүүд	Хамрах сэдэв	Дасгал ажил	Дасгалын зорилго
Хичээл 2.1. Иргэдийн хяналтын бүлэг	<ul style="list-style-type: none"> Иргэдийн хяналтын бүлэг, түүний эрх зүйн чадамж Иргэдийн хяналтын бүлэг юуг хянах вэ? Иргэдийн хяналтын бүлгийг байгуулах Иргэдийн хяналтыг хэрэгжүүлэх үе шат 	<ul style="list-style-type: none"> Орон нутгийнхаа баг, хорооны ИНХ-ын дэргэд иргэдийн хяналтын бүтцийг байгуулах төлөвлөгөө боловсруулах, ИНХ-ын дарга, Хорооны засаг дарга дэмжихгүй тохиолдолд иргэдийн бие даасан хяналтын бүлэг байгуулах төлөвлөгөө боловсруулах 	Иргэдийн хяналтын бүлэг байгуулах мэдлэг ур чадвар олгох
Хичээл 2.2. ИТХ-ын хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэхэд иргэдийн оролцоо	<ul style="list-style-type: none"> ИТХ-ын дэргэд Төсвийн хяналтын хороо байгуулах аргачлал 	Орон нутгийнхаа баг, хорооны ИНХ-ын дэргэд иргэдийн хяналтын бүтцийг байгуулах төлөвлөгөө боловсруулах	Иргэдийн хяналтын бүлэг байгуулах, үр дүнтэй ажиллах ур чадвар олгох
Хичээл 2.3. Төсвийн хяналтын сонголт зохион байгуулах арга зүй	<ul style="list-style-type: none"> Нийтийн сонголт гэж юу вэ? Сонголтын төрөл Төсвийн хяналтын сонголт зохион байгуулах арга зүй 	Төсвийн хяналтын сонголт зохион байгуулах жүжигчилсэн тоглолт	Оролцогчдыг төсвийн хяналтын сонголыг зохион байгуулах дадлага ажил хийлгэж, мэдлэг ур чадварыг нэмэгдүүлэх

Хичээл 2.1. Иргэдийн хяналтын бүлэг

Зорилго	Авлигатай тэмцэх иргэдийн оролцооны нэг хэлбэр болох иргэдийн хяналтын бүлгийн талаар мэдээлэл өгч, түүнийг байгуулах, хяналтыг хэрэгжүүлэх арга замуудтай танилцуулах, дадлагажуулах
Зорилтот бүлэг	<ul style="list-style-type: none">• Иргэний нийгмийн сургагч багш нар
Дэд сэдвүүд	<ul style="list-style-type: none">• Иргэдийн хяналтын бүлэг, түүний эрх зүйн чадамж• Иргэдийн хяналтын бүлэг юуг хянах вэ?• Иргэдийн хяналтын бүлгийг байгуулах• Иргэдийн хяналтыг хэрэгжүүлэх үе шат
Зохион байгуулах алхмууд	<ul style="list-style-type: none">• Сэдэлжүүлэх дасгал ажил – 30 мин• Мэдлэг олгох лекц 1 – 60 мин• Мэдлэг олгох лекц 2 – 40 минут• Мэдлэг бататгах дасгал – 30 мин• Сургалтын үнэлгээ – 20 минут
Сургалтын хэрэглэгдэхүүн	<ul style="list-style-type: none">• Хичээлийн слайд• Сургалтын техник: самбар, проектор, нотебүүк• Маркер, флипчарт, цаас, скоч

Сургагч багшид зориулсан зөвлөгөө

Иргэдийн төсвийн хяналтын бүтцийг баг, хорооны ИНХ-ын дэргэд хэрхэн зохион байгуулах талаар танилцуулна. Үүнд: иргэдийн хяналтын бүлгийг баг, хороо бүрд таваас доошгүй хүний бүрэлдэхүүнтэй байгуулж болох бөгөөд энэ ажлыг орон нутгийн ТББ-ууд удирдан хийх нь үр дүнтэй байгааг жишээ баримтаар харуулна. Хяналтын бүлгийг ИНХ-ын дэргэд байгуулж, ИНХ-ын тогтоолоор албажуулдаг. Хэрвээ ИНХ-ын дэргэд байгуулж чадахгүй бол иргэдийн хяналтын бие даасан бүлэг байгуулах боломжтой гэдгийг оролцогчдод тайлбарлан бүлэг байгуулах арга зүйтэй дэс дараатай танилцуулна.

Сэдэлжүүлэх дасгал ажил

Заавар: 2021 оны 9-р сарын 2-ны Орхон аймгийн 17-р сургуулийн барилгын 1-р давхарт цууралт үүсч, нуралт өгсөн жишээг ярилцана. Тус барилгыг орон нутгийн төсвийн 2.3 тэрбум төгрөгөөр барьж, 2017 оны нэг сард ашиглалтад оруулсан ч 4 жилийн дараа барилга нурж 600 орчим хүүхэд танхимд хичээллэх боломжгүй болжээ. Тус жишээг танилцуулахдаа холбогдох мэдээний бичлэг¹² үзүүлэх болон доорх зургийг харуулан ярилцана.

Зураг 3. 1. Иргэдийн хяналтгүй газар сургууль нурж, зам эвдэрдэг сэдэвт зураг

Ямар учраас ийм тохиолдлууд гарсан бэ? Хэрэв иргэд хяналтаа хэрэгжүүлж, холбогдох байгууллага, албан тушаалтанд шаардлага тавьж, хариуцлага нэхдэг бол байдал ямар байх вэ? зэрэг асуултыг тавьж, хэлэлцүүлэн иргэдийн хяналтыг хэрэгжүүлэх сэдэл төрүүлнэ.

¹² <https://www.facebook.com/watch/?v=6035741243164715>

Мэдлэг олгох лекц 1- ийн товч агуулга:

Иргэдийн хяналтын бүлэг байгуулах эрх зүйн үндэслэл. ИНХ нь Үндсэн хууль болон холбогдох хуульд зааснаар хуулиар олгогдсон эрх хэмжээний дотор нутаг дэвсгэрийнхээ асуудлаар бие даан шийдвэр гаргах, хэм хэмжээ тогтоох эрхтэй өөрийн удирдлагын байгууллага юм¹³. Баг, хорооны ИНХ-ын тогтоолоор Иргэдийн хяналтын бүлэг албажина.

Иргэдийн хяналтын бүлэг гэж юу вэ? Иргэдийн хяналтын бүлэг нь оршин суугаа газартаа хэрэгжиж буй хөрөнгө оруулалт, төсвийн зарцуулалтад хяналт тавих зорилготой зохион байгуулалтад орсон иргэдийн нэгдэл юм¹⁴.

Иргэдийн хяналтын бүлэг юуг хянах вэ? Баг, хороонд иргэдийн хяналтын бүлгийг байгуулснаар төрийн хөрөнгө оруулалт төдийгүй ОНХС- шийдвэр гаргах ба хэрэгжүүлэх үе шатуудад хяналт тавигдана. Үүнд:

1. **Иргэдээс санал асуулга авах явцад хяналт тавих.** ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрүүдэд иргэдээс санал асуулга авах үйл ажиллагаанд байнгын хяналт тавих болсноор иргэдийн оролцоо сайжирч, өрх бүрийн санал тэр тусмаа алслагдсан, амьжиргааны төвшин доогуур, орхигдсон хэсгийн саналыг тусгах боломж сайжирна.
2. **Иргэдээс авсан саналыг эрэмбэлэх явцад хяналт тавих.** Иргэдийн саналыг хорооны ба дүүргийн төвшинд эрэмбэлэх үйл явцад хяналт тавьснаар иргэдийн олонхын саналыг авсан төсөл, хөтөлбөр орхигдох, солигдох зэрэгт хяналт тавьж, нийтийн эрхийг хамгаалж чадна.
3. **Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих.** Иргэдийн саналаар шийдэгдсэн тэргүүлэх ач холбогдолтой төсөл хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнд байнгын хяналт тавигдаж, үр дүнг оршин суугчдад тайлагнах тогтолцоо бүрдэнэ.

Иргэдийн хяналтын бүлэгт хэн ажиллаж болох вэ?

- Тухайн хорооны байнгын оршин суугч
- Цаг зав, сэтгэл зүрхээ зориулан ажиллах хүсэл эрмэлзэлтэй хүн бүр
- Гүйцэтгэгч байгууллага, иргэдийн бүтээн байгуулалтын бүлэгтэй хамааралгүй этгээд байвал зохино.
- Хууль эрх зүй болон санхүү, инженер, техникийн тодорхой мэдлэг, туршлагатай байвал давуу тал болно

“Иргэдийн хяналтын бүлэг” байгуулах үе шат

¹³ Үндсэн хуулийн 62.1, 62.2, 63.1, 63.2

¹⁴ Сосормаа Ч., “Иргэд төсвөө хянана” Төлөөллийн байгууллагын хяналтын чиг үүргийг иргэдийн оролцоотой чадавхжуулах тухай, Гарын авлага. УБ, 2020, хууд 38



Нэг. Бэлтгэл үе шат

Хоёр. Хяналтын бүлэг байгуулах үе шат

Гурав. Бүлгийн гишүүдийг чадавхжуулах үе шат

Дөрөв. Хяналтыг хэрэгжүүлэх үе шат

Тав. Нөлөөллийн үе шат

Зураг 2. 2. Иргэдийн хяналтын бүлэг байгуулах үе шат

Нэг. Бэлтгэл үе шат

Баг, хорооны ИНХ-ын ба Засаг даргатай хамтран ажиллана. Тухайлбал: Хорооны Засаг даргатайгаа хамтран ажиллах шийдвэрт хүрсэн байна. Хяналтын үйл ажиллагаа Засаг даргын ажилд ч тустай байдаг тул Засаг дарга дэмжиж, хамтдаа ажилладаг сайн туршлагууд олон байна.

Бэлтгэл ажлын хүрээнд:

1. Хяналтын бүлгийн гишүүдэд тавигдах ерөнхий шаардлага бэлтгэнэ. Тухайлбал: Олон нийтийн ажил хийх, хүсэл сонирхол, цаг завтай байх, тухайн хорооны иргэн байх, түүнчлэн хууль эрх зүй, эдийн засаг, барилгын чиглэлээр мэргэшсэн байвал давуу тал болно гм.
2. Хяналтын бүлэгт сайн дураар ажиллах боломжтой иргэдийн судалгааг гаргана.
3. Хяналтын бүлгийн ажиллах журмын төслийг бэлтгэнэ.

Анхаарах зүйлс:

- *ИНХ-ын дарга ба Хорооны Засаг даргын хамтын манлайллаар Иргэдийн хяналтын бүлгийн үйл ажиллагаа амжилттай хэрэгжих тул хорооны Засаг даргын дэмжлэгийг авч хамтран ажиллах нь ач холбогдолтой.*
- *Иргэдийн хяналтын үйл ажиллагааг аливаа улс төрийн зохисгүй үйлдэл, улс төрийн намуудын нөлөөлөл, сонгуулийн сурталчилгаанаас ангид байлгах шаардлагатай.*
- *Хяналтын бүлгийн гишүүд нь нам бус болон ямар ч улс төрийн намын гишүүн байж болох ч үндсэн зарчмаа баримталж, хараат бусаар ажиллаж байж үр дүнд хүрнэ. Иймээс иргэдийн хяналтын үйл ажиллагааг улс төрийн намуудын зөрчил, тэмцлийн талбар болгохгүй байхад анхаарна уу!*

Хоёр. Иргэдийн хяналтын бүлгийг байгуулах үе шат

Баг, хорооны Нийтийн хурлыг хуралдуулж Хяналтын бүлэгт орох төлөөллийг иргэдээс хоёр жилийн хугацаатай сонгуулна. Нийтийн хурлаас сонгогдоно гэдэг хөршүүдийнхээ өмнө үүрэг хүлээж байгаа хэрэг юм. Нийт оршин суугчдаасаа итгэл хүлээн сонгогдсон гишүүд эргээд тэдний өмнө ажлын гүйцэтгэлээ тайлагнах үүрэг хүлээдэг. Нийтийн хуралд жил бүр ажлаа тайлагнаж, хоёр жил тутам сонгууль явуулж, идэвхи зүтгэлтэй ажиллаж байгаа гишүүд нь дахин сонгогдож байх нь зүйтэй.

Баг, хорооны хяналтын бүлэгт 5 доошгүй гишүүдтэй байж болно. Гэхдээ өөрсдийн нөхцөлдөө тохируулан тоогоо тогтоож болно. Түүнчлэн тус хороонд үйл ажиллагаа явуулдаг орон нутгийн ТББ, залуучуудаас оруулах зэргээр аль болох тал бүрийн төлөөллийг оролцуулах нь чухал.

1. Баг, хорооны нийтийн хурлаас сонгогдсон иргэдийг ИНХ-ын тогтоолоор баталгаажуулан Хяналтын бүлгийг байгуулж албажуулна,
2. Хяналтын бүлгийн журмыг батална.
3. Хяналтын бүлгийн даргаа гишүүд дотроосоо сонгоно.
4. Бүлгийн гишүүд ёс зүйн зарчмуудаа батална.

Анхаарах зүйлс:

- *Иргэдийн хяналтын ажил бол сайн дурын ажил тул энэхүү ажлыг хийх хүсэл сонирхолтой байх нь хамгийн чухал. Хяналтын аргуудыг эзэмшин мэргэших замаар хувь хүн өсөн хөгжих өргөн боломж бий гэдгийг гишүүддээ ойлгуулахаас ажил эхэлнэ. Түүнчлэн гудамж, хороондоо барьж байгуулж байгаа ажилд хяналт тавьж сайжруулна гэдэг бол нийтийн сайн сайхны төлөө хийж байгаа үнэ цэнтэй ажил мөн гэсэн итгэл үнэмшилтэй болгох нь чухал.*
- *Бүлгийн гишүүдийг бүрдүүлэхдээ хүсэл сонирхол, цаг заваас гадна нас, хүйс, ажлын туршлага, мэдлэгийг харгалзах нь зүйтэй.*
- *Бүлгийн гишүүд ёс зүйн зарчмуудаа хамтаараа боловсруулж батлах нь зүйтэй. Бүлгийн гишүүдийн баримтлах үндсэн зарчим бол ёс зүйтэй байх, мэргэшсэн байх, хараат бусаар ажиллах явдал мөн.*

Гурав. Хяналтын бүлгийн гишүүдийг чадваржуулах үе шат

Мэдээлэлтэй иргэн мэдлэгтэй, мэдлэгтэй иргэн эрх мэдэлтэй байдаг. Хяналтын бүлгийн гишүүдийг сургаж, чадваржуулах ажил нэн чухал. Сургалтаар төсвийн хөрөнгө оруулалт ба ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд мониторинг хийх, нөлөөлөх чадварт гишүүдийг сургана.

Сургалтыг дүүргийн ИТХ ба иргэний нийгмийн байгууллагууд хамтран зохион байгуулж, мэргэжлийн хүмүүсийг урьж оролцуулах боломжтой. Түүнчлэн бусад хороо ба дүүрэгтэй туршлага солилцох уулзалт, хэлэлцүүлэг хийх нь ач холбогдолтой байдаг. Хяналтын бүлгийн хурлыг тогтмолжуулах (сард нэгээс доошгүй удаа) Бүлгийн гишүүд ИНХ-д хяналтын тайлангаа тавих, баг, хороодын иргэддээ ажлаа тайлагнах чадварт сургана. Түүнчлэн дүүргийн ИТХ-д ажлаа тайлагнах, зөвлөмж бичих, нөлөөлөх чадваруудыг эзэмшинэ. Юуны өмнө дараах чадварыг эзэмших шаардлагатай. Үүнд:

- Төсвийн тухай ерөнхий мэдлэг эзэмших
- ОНХС-ийн тухай өргөн хүрээний ойлголттой болох
- Төсвийн хяналт хийх арга зүйд суралцах
- Холбогдох хууль тогтоомжийг судлах
- Төрийн байгууллагаас мэдээлэл хүсэх, өргөдөл бичих, цахим хуудас ашиглаж тендерийн материалыг эрж хайх, ашиглах чадварт суралцах
- Хяналтын бүлгийн гишүүдэд тусламж болох гарын авлага ялангуяа зам гүүр барих, худаг гаргах, гэрэлтүүлэг хийх зэрэг ажлуудын стандарт, дүрэм, журмыг олж авах, хэрэглэж сурах
- Шийдвэр гаргагч нарт нөлөөлөх чадварууд
- Багаар ажиллах чадвар, ёс зүйн сургалтууд зэрэг болно.

Анхаарах зүйлс:

- *Иргэдийн төсвийн хяналт шинэ ойлголт тул мэргэшсэн байгууллагуудтай холбогдон сургалт авч байх нь чухал.*
- *Багийн гишүүдэд хяналт хийхийн ач холбогдлыг ойлгуулж, итгэл үнэмшил төрүүлж, хараат бус байх зарчмыг баримтлан ажиллах үнэ цэнийг мэдрүүлэх нь юунаас ч илүүтэй.*
- *Мэргэшүүлэх сургалтаас гадна зан харилцааны сургалт ч чухал. Багаараа ажиллах тул нэгнээ хүндэтгэх, багийнхаа өмнө хариуцлага хүлээх, зөрчил, маргаанаа шийдвэрлэх чадварууд ч чухал байдаг. Багийн гишүүд гар нийлж байж л үр дүнтэй ажиллана.*

Мэдлэг бататгах дасгал ажил:

1. Оролцогчдыг багт хуваарилж хяналтын бүлгийн гишүүдийг чадваржуулах төлөвлөгөө боловсруулах даалгавар өгнө.
2. Багууд чадавхжуулах төлөвлөгөөг танилцуулж, хэлэлцүүлэг өрнүүлнэ.

Мэдлэг олгох лекц 2-ийн товч агуулга

Хяналтыг хэрэгжүүлэх үе шат

Зорилгоо тодорхойлж, ажлын төлөвлөгөө гаргах. Бүлгийн гишүүд зорилгоо тодорхойлж, ажлын төлөвлөгөө гаргахаас хяналтын ажил эхэлнэ. Хэн, ямар ажил хариуцах, ямар хугацаанд хийх болон ямар үр дүн хүлээж байгаагаа төлөвлөнө. Эдгээр ажлуудыг ямар аргууд хэрэглэн хэрхэн хяналт тавихаа нэг бүрчлэн төлөвлөж бичнэ. Түүнчлэн ямар алдаа, эрсдэл гаргаж болзошгүй түүнээс хэрхэн урьдчилан сэргийлэх боломжтойг таамаглан бичвэл тустай.

Мэдээлэл цуглуулах. Баг, хороонд хийгдэж байгаа бүтээн байгуулалтын ажлын тендерийн баримт бичгийг олж авч судална. Баримт бичигт дурдсан ажлууд дэс дараалал, хугацаандаа хийгдэж байгаа болон гэрээнд заагдсан үр дүнд хүрсэн эсэхийг хянах асуулга бүхий хүснэгт бэлтгэхийг зөвлөж байна.

Стандартууд бэлтгэх. Түүнчлэн бүтээн байгуулалтын ажлыг хянан шалгах энгийн стандартуудыг бэлтгэсэн байна. Шаардлагатай тохиолдолд мэргэжлийн зөвлөх ажиллуулан, санал дүгнэлтийг тусгавал ач холбогдолтой.

Хяналт бол төсөл, хөтөлбөрийг төлөвлөгөөний дагуу гүйцэтгэж байгаа эсэхийг хянан, алдаа дутагдлыг засч залруулах үйл ажиллагаа юм.

Хяналт үндсэн 3 үе шаттай.

1. **Ажил эхлэхийн өмнөх буюу бэлтгэл үеийн хяналт.** Энэ үе шатанд тендер шалгаруулах үйл явц, тендерийн баримт бичигтэй танилцах, судлах, тендерт шалгарсан аж ахуйн нэгж бэлтгэл ажлаа хангаж байгаа зэрэгт хяналт тавина.
2. **Хэрэгжилтийн хяналт.** Энэ үе шатанд ажлын явц, төслийн зорилгод чиглэж байгаа эсэх, төлөвлөгөөний дагуу цаг хугацаандаа дэс дараа, стандартын дагуу чанартай хийгдэж байгаад хяналт тавина.
3. **Үр дүнгийн хяналт.** Энэ үе шатны хяналт ажил дууссаны дараа хийгдэнэ. Орон нутагт хийгдэж дууссан ажлыг хүлээн авахад эсвэл хүлээн авснаас хэсэг хугацааны дараа хэрэгждэг. Ялангуяа ажил гүйцэтгэсэн аж ахуйн нэгжийн өгсөн баталгаат хугацаа дуусахаас өмнө хяналт тавьж чанаргүй эсвэл дутуу хийсэн ажлуудыг илрүүлэх нь хугацаа алдалгүй сайжруулахад дэм болно. Энэ үе шатанд хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн үнэлгээг давхар авч үнэлүүлэх нь тустай.

Анхаарах зүйлс:

- Хяналтын бүлгийн гишүүд үнэмлэхтэй байвал сайн. Ийм үнэмлэхийг хороо эсвэл дүүргээсээ авч болно.
- Хяналт ба үнэлгээг гүйцэтгэгч байгууллагын үйл ажиллагаанд саад бэрхшээл учруулахгүйгээр зохион байгуулахыг хичээвэл сайн.
- Харсан бүхнээ бичлэг, тэмдэглэл хөтлөж баримтжуулж байх хэрэгтэй.

- *Хяналт, үнэлгээ хийж байхдаа гүйцэтгэгч талтай маргалдаж, муудалцаж болохгүй!. Хэрвээ тэд объектоо нэвтрүүлэхгүй эсвэл хүссэн баримт бичгийг үзүүлэхгүй бол холбогдох төрийн захиргааны байгууллагад хандаж мэдээлэл авах эрхтэй. Хүссэн иргэнд шалтгааныг асуухгүйгээр мэдээлэл гаргаж өгөх үүргийг төрийн байгууллага хуулиар хүлээсэн болно.*
- *Хяналт, үнэлгээний ажлаа эхлэхийн өмнө Хорооны Засаг даргын албан бичиг гүйцэтгэгч байгууллагад илгээх болон эдгээр удирдлагуудтай хамт очиж болно.*

Нөлөөллийн үе шат

Нөлөөллийн үйл ажиллагааг төлөвлөхдөө ямар асуудлыг, хэзээ, хэрхэн, хэнд нөлөөлөх замаар сайжруулах вэ гэсэн асуултад хариулах шаардлагатай болно.

Аж ахуйн нэгж байгууллагууд төсвийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ гүйцэтгээд орон нутгийн захиргааны байгууллагад хүлээлгэн өгөх хуулиар хүлээсэн үүрэгтэй. Тэдний хийсэн ажлыг хүлээн авах албан ёсны комисс гардаг хэдий ч шаардлага хангахгүй ажлуудыг хүлээн авсан байдаг. Шинээр барьсан худгаас уухын аргагүй саарал ус гараад байдаг. Хүүхдийн гаднах талбайн тоглоомуудыг хүүхдэд аюултай будгаар будсан байх жишээтэй. Халуун усны шинэхэн газрын тааз халуун ууранд цохиулаад нурах тохиолдол бишгүй.

Иргэдийн хяналтын бүлгийн зорилго бол төрийн байгууллагыг хариуцлагатай болгоход чиглэнэ. Өөрөөр хэлбэл чадваргүй компанийг тендерт ялагчаар тодруулаад, чанар муутай ажлыг нь хүлээж аваад байгаа төрийн албан хаагчдын хариуцлагыг дээшлүүлэх явдал юм.

Хяналтын бүлгийн гишүүд хяналт, үнэлгээний ажлынхаа үр дүнг хоёр чиглэлээр тайлагнана. Үүнд:

1. Баг, хорооны нийтийн хуралд ажлаа тайлагнаж, иргэдийн өмнө хийсэн ажлаа үнэлүүлнэ.
2. Дүүргийн ИТХ-д ажлаа танилцуулж, зөвлөмж хүргүүлнэ. Дүүргийн ИТХ-аас Иргэдийн хяналтын бүлгийн зөвлөмжид тулгуурлан Дүүргийн ЗДТГ-д тухайн ажлыг сайжруулах үүрэг өгдөг. Харин хяналтын бүлгийнхэн ИТХ-өөс өгсөн үүрэг хэрэгжиж байгаад хяналтаа үргэлжүүлэн хийнэ.

Мэдлэг бататгах дасгал ажил

Оролцогчдыг хоёр багт хуваан дараах даалгаврыг өгнө. Үүнд:

- Орон нутгийнхаа баг, хорооны ИНХ-ын дэргэд иргэдийн хяналтын бүтцийг байгуулах төлөвлөгөө боловсруулах,
- ИНХ-ын дарга, Хорооны засаг дарга дэмжихгүй тохиолдолд иргэдийн бие даасан хяналтын бүлэг байгуулах төлөвлөгөө боловсруулах

Эх сурвалж:

- Улс, орон нутгийн төсвийн болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжиж буй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд иргэдийн оролцоотой хяналт- үнэлгээ хийх аргачлал. Дэлхийн банк MASAM II төсөл. 2023 он
- Сосормаа Ч., “Иргэд төсвөө хянана” Төлөөллийн байгууллагын хяналтын чиг үүргийг иргэдийн оролцоотой чадавхжуулах тухай, Гарын авлага. УБ, 2020
- “Иргэдээ сонсож, иргэдтэйгээ зөвлөлдөж, хөгжлийг хамтдаа бүтээхүй” ИТХ-ын төлөөлөгч нарт зориулсан гарын авлага, Ч.Сосормаа нар, ЕТГ. 2012

- “Our money, our responsibility” A citizen’s guide to monitoring government expenditures, by Vivek Ramkumar, The international budget project, 2008
- Social Audit: A Toolkit a guide for performance improvement and outcome measurement.
<http://unpan1.un.org/intradoc/groups/public/documents/cgg/unpan023752.pdf>
- Community based monitoring toolkit, Integrity Watch Afghanistan
- <http://toolkit.communitymonitoring.org/> 2015

Эрх зүйн баримт бичиг

- Засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль 2020
- Төсвийн тухай хууль, 2012
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, 2023
- Төрийн аудитын тухай хууль, 2020
- Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам Сангийн сайдын 2021 оны 5 дугаар сарын 24-ны өдрийн 86 дугаар тушаалын хавсралт
- Шилэн дансны тухай хууль, 2022 он

Хичээл 2.2. ИТХ-ын хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэхэд иргэдийн оролцоо

Зорилго	<ul style="list-style-type: none"> ИНХ-ын дэргэд иргэдийн хяналтын бүтцийг бүрдүүлэх арга замуудтай танилцуулах, дадлагажуулах
Хугацаа	<ul style="list-style-type: none"> 120 минут
Зохион байгуулалт	<ul style="list-style-type: none"> Асуудал дэвшүүлсэн ярилцлага -20 мин Мэдлэг олгох-лекц -40 мин Мэдлэг бататгах дадлага ажил, сургалтын үнэлгээ - 60 мин
Аргачлал	<ul style="list-style-type: none"> Асуудал дэвшүүлэх, сэдэлжүүлэх Лекц Видео бичлэг үзүүлэх Багаар ажиллах Дадлага ажил Асуулт, хариулт
Хэрэглэгдэхүүн	<ul style="list-style-type: none"> Танилцуулга 12 слайд Холбогдох хууль, журам Проектор, дэлгэц Маркер, флипчарт, цаасан скоч
Үнэлгээ	<ul style="list-style-type: none"> Бататгах асуулт, хариулт

Сургагч багшид өгөх зөвлөмж:

ИТХ-ын төсвийн хяналтыг иргэдийн оролцоотой хэрэгжүүлэх арга замууд, сайн туршлагаудыг танилцуулна. Үүнд: Дорнод аймгийн салбарын санаачилгаар 2014 онд Хэрлэн сумын ИТХ-ын дэргэд Хяналт, үнэлгээний олон нийтийн зөвлөл (Хавсралт 2.2) , Захиргааны шинэ санаачилга ТББ-аас 2019 онд Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын ИТХ-ын дэргэд Хяналтын хороо (Хавсралт 2.3.), Булган аймгийн салбарын санаачилгаар Булган аймгийн ИТХ-тай хамтран ажиллах санамж бичиг байгуулан түншлэн ажилласан (Хавсралт 2.4)-ийн туршлагаудыг видео ба үзүүлэнгээр танилцуулна.

Сэдэлжүүлэх дасгал ажил:

Заавар: Асуудал дэвшүүлсэн ярилцлага: ИТХ-ын төлөөлөгчид Засаг даргын мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийг өндөр хувьтай үнэлдэг шалтгаан юу вэ? ИТХ жил бүр төсвийн хяналтын сонголт зохион байгуулах хуулиар хүлээсэн үүргээ ч биелүүлдэг үү?

Төлөөллийн байгууллага буюу ИТХ хяналтын ямар чиг үүргүүдийг хэрэгжүүлдэг, хэрхэн хэрэгжүүлдэг талаар ярилцана. Тэр дундаа төсвийн хяналтын чиг үүргээ үр дүнтэй хэрэгжүүлж чаддаг уу? Эсвэл дутуу хэрэгжүүлдэг үү? гэсэн асуудлаар ярилцаж шалтгааныг хэлэлцэнэ. Үүнд: ИТХ нь Засаг даргын мөрийн хөтөлбөрийг хэрэгжилтийг хянаж, Засаг даргад хариуцлага тооцох, огцруулах хүртэлх арга хэмжээ авах эрх мэдэлтэй субъект боловч энэхүү чиг үүргээ хэрэгжүүлдэггүй, жил бүр төсвийн хяналтын сонголт зохион байгуулах хуулиар хүлээсэн үүргээ ч биелүүлдэг эсэх тухай ярилцаж, улмаар засаглалын эрх мэдлийн хуваарилалт, харилцан хянах зарчим алдагдаж буйг жишээ баримтаар эшлэнэ. Эндээс дараах асуудлуудаар дүгнэлт хийнэ. Үүнд:

- Шинэ тутам ардчиллыг хөгжүүлж буй улс оронд төлөөллийн ардчиллын институци (ИТХ, УИХ) иргэдийн эрх ашгийг төлөөлөх бус нам, бүлгийн эрх ашигт үйлчлэх

зэрэг сул талууд байдгаас хяналтын чиг үүргээ хараат бусаар хэрэгжүүлэх чадвар сул байдаг.

- Иргэдийн оролцоотой төсвийн хяналтыг хэрэгжүүлэх механизмыг бүрдүүлснээр төлөөллийн ардчиллын сул талыг нөхөж, нийгмийн эгэх хариуцлагыг сайжруулдаг. Өөрөөр хэлбэл төлөөллийн ба шууд ардчиллыг хослуулан хэрэгжүүлэх замаар засаглалыг сайжруулна.

Сэдэвтэй холбоотой мэдээлэл:

ИТХ-ын дэргэд Төсвийн хяналтын хороо байгуулах аргачлал

Төсвийн хяналтын хороо (цаашид Хяналтын хороо гэнэ) дараах чиглэлээр ИТХ-ын төсвийн хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэх боломжтой. Үүнд:

- ИТХ-ын хуралдаанаар батлагдсан хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт,
- Улсын ба орон нутгийн өмчийн ашиглалт, хамгаалалт, зарцуулалт, өр авлагын асуудал,
- ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтад иргэдийн саналыг авах, эрэмблэх, төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэх, хэрэгжилт, үр дүнг хянах,
- Төрийн болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд хяналт тавих,
- Шилэн дансны үйл ажиллагаанд хяналт тавих,
- Хуулиар олгогдсон бусад бүрэн эрхийн асуудлууд зэрэг юм.

Хяналтын хорооны бүтэц, бүрэлдэхүүн, зохион байгуулалт¹⁵

Эрхзүйн үндэслэл: Хяналтын хороог ИТХ-ын тогтоолоор байгуулна. Хяналтын хорооны журмыг батална.

Хяналтын хорооны гишүүдийн бүтэц, бүрэлдэхүүн: Хяналтын хороо нь ИТХ-ын төлөөлөгчид, ТББ-ын төлөөлөл, иргэдийн бүрэлдэхүүнтэй байгуулагдана. Тухайлбал: Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын Хяналтын хорооны гишүүдэд ИТХ-ын төлөөлөгч-5, ТББ-уудын зөвлөлийн хурлаас сонгогдсон төлөөлөл-3, багийн ИНХ-аас сонгогдсон иргэдийн төлөөлөл 7 иргэн (7 багаас тус бүр 1 иргэн) байв.

Хяналтын хорооны гишүүдийн тоо: Хяналтын хороо сондгой тоотой байх ба хамгийн багадаа 9 хүнтэй байвал зохимжтой. Гишүүдийн тоог журмаар тогтооно.

Анхаарах зүйлс:

ИТХ-ын дэргэдэх хяналтын хороонд иргэдийн төлөөллийг оролцуулахдаа баг, хорооны хяналтын бүлгийн гишүүд дотроос сонгогдсон төлөөллийг, харин ТББ-ын төлөөллийг оролцуулахдаа ТББ-ууд өөрсдөө сонгож санал болгосон төлөөллийг оруулна. ИТХ өөрсдөө сонгон (намын харьяалал, ах дүү, найз нөхдөө сонгох эрсдэлтэй) иргэдийн төлөөлөл оролцуулж хэрхэвч болохгүй. Хяналтын хороонд ажиллах иргэдийн төлөөллийн тоо төлөөлөгчдөөс дутуугүй ижил эсвэл илүү байхыг зөвлөж байна.

Анхаарах зүйлс:

ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороо нь иргэдийн төлөөллийн саналыг хүндэтгэж, хараат бусаар ажиллах боломжийг олгож байж, хамтран үр дүнтэй ажиллаж чадна.

¹⁵ Дорнод аймгийн Хэрлэн сумын ИТХ-ын дэргэдэх Хяналт, үнэлгээний зөвлөл, Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын ИТХ-ын дэргэдэх Хяналтын хорооны загварыг ашиглав.

Хяналтын хорооны чиг үүрэг төсвийн хяналтаар дагнасан эсвэл өргөн хүрээтэй байж болно. Тухайлбал:

- ЗДТГ-ын шилэн дансыг хянах,
- Худалдан авалтын үйл ажиллагааг хянах
- Төрийн ба орон нутгийн төсөв, ОНХС-ийн зарцуулалтыг хянах
- Төрийн үйлчилгээнд мониторинг хийх,
- Газар олголт, хот төлөвлөлт,
- Орон нутагтаа олгосон ашигт малтмалын тусгай зөвшөөрөл, ашигт малтмалын гэрээ эзэмшигч ба орон нутгийн удирдлагын хамтын гэрээний хэрэгжилтэд хяналт тавих зэрэг тухайн орон нутгийнхаа онцлогоос шалтгаалан тулгамдсан асуудлуудыг оруулж болно.

Иргэдийн хяналт эхлэхийн өмнө сум дүүргийн ИТХ-ын дэргэдэх Хяналтын хорооноос ажил гүйцэтгэгч компаниудтай уулзаж, ажлын төлөвлөгөөтэй танилцах, иргэдийн оролцоотой хяналт тавих тухайгаа урьдчилан танилцуулах нь хяналтыг үр дүнтэй болгодог.

Мэдлэг бататгах дасгал ажил

Сумын ИТХ-тай хамтран ажиллах бүтцээ тодорхойлох даалгавар өгнө. Үүнд:

1. ИТХ-ын дэргэд иргэдийн оролцоотой Хяналтын хороо шинээр байгуулах
2. ИТХ-ын дэргэдэх Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх ажилд хөндлөнгийн хяналт, үнэлгээ хийх багийн бүрэлдэхүүнд иргэд ба ИНБ-ын төлөөлөл орж ажиллах
3. ИТХ-тай хамтран ажиллах санамж бичиг байгуулан ажиллах, өөрийнхөө сумын ИТХ-тай ямар загвараар ажиллах боломжтойг ярилцана.

Эх сурвалж:

- Улс, орон нутгийн төсвийн болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжиж буй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд иргэдийн оролцоотой хяналт- үнэлгээ хийх аргачлал. Дэлхийн банк MASAM II төсөл. 2023 он
- Сосормаа Ч., “Иргэд төсвөө хянана” Төлөөллийн байгууллагын хяналтын чиг үүргийг иргэдийн оролцоотой чадавхжуулах тухай, Гарын авлага. УБ, 2020
- Булган аймгийн ЛЭОС-ийн салбар зөвлөлийн тайлан (хэвлэгдээгүй)
- “Our money, our responsibility” A citizen’s guide to monitoring government expenditures, by Vivek Ramkumar, The international budget project, 2008
- Social Audit: A Toolkit a guide for performance improvement and outcome measurement.
<http://unpan1.un.org/intradoc/groups/public/documents/cgg/unpan023752.pdf>
- Community based monitoring toolkit, Integrity Watch Afghanistan
- <http://toolkit.communitymonitoring.org/> 2015

Эрх зүйн баримт бичиг

- Засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль 2020
- Төсвийн тухай хууль, 2012
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, 2023
- Төрийн аудитын тухай хууль, 2020

- Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам Сангийн сайдын 2021 оны 5 дугаар сарын 24-ны өдрийн 86 дугаар тушаалын хавсралт
- Шилэн дансны тухай хууль, 2022 он

Хичээл 2.3. Төсвийн хяналтын сонсгол зохион байгуулах арга зүй

Зорилго	<ul style="list-style-type: none"> Төсвийн хяналтын сонсгол зохион байгуулах аргачлалтай танилцуулж, төсвийн хяналтын сонсгол зохион байгуулахад ИТХ-д нөлөөлөх чадвартай болгох
Хугацаа	150 мин
Үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> Сэдэлжүүлэх дасгал-30 мин Мэдлэг олгох лекц – 60 мин Мэдлэг бататгах дадлага ажил- 60 мин Багуудын жүжигчилсэн тоглолт – 60 мин Үнэлгээ - 30 мин
Аргачлал	<ul style="list-style-type: none"> Лекц, танилцуулга Жүжигчилсэн тоглолт Асуулт, хариулт
Хэрэглэгдэхүүн	<ul style="list-style-type: none"> Танилцуулга 10 слайд Холбогдох хууль, журам Техник хэрэгсэл: Проектор, дэлгэц Тараах материал: Сонсгол зохион байгуулах аргачлал
Үнэлгээ	<ul style="list-style-type: none"> Мэдлэг бататгах асуулт, хариулт

Сургагч багшид өгөх зөвлөгөө:

Төсвийн хяналтын сонсголын эрх зүйн орчныг танилцуулж, орон нутагт төсвийн хяналтын сонсгол зохион байгуулагдахгүй байгаа шалтгааныг хэлэлцэж, нөлөөллийн ажил хийх арга замуудыг тайлбарлаж, санал солилцоно. Иргэдийн төсвийн хяналт, мониторингийн үр дүнг хэлэлцэх талбар бол төсвийн хяналтын сонсгол болохыг ойлгуулж, анхаарлын төвд оруулна.

Сэдэлжүүлэх дасгал ажил

Багш дараах зургийг харуулан бүгд шүүмжлэх дуртай ч асуудлыг шийдвэрлэх шинэлэг арга барил санал болгох, бүтээлчээр оролцох хүн цөөн байдаг тухай ярилцана. Иргэд, ИНБ-ууд төр засгийн үйл ажиллагааг хоосон шүүмжлээд суух биш харин бүтээлчээр оролцож, түншлэн ажиллах нь нэн чухал. Бүтээлч оролцооны нэг жишээ бол Төсвийн хяналтын сонсголыг зохион байгуулахад бүтээлчээр оролцох явдал гэдгийг тайлбарлан сэдэлжүүлнэ.



Сэдэвтэй холбоотой мэдээллийн товч агуулга:

Нийтийн сонгогч гэж юу вэ?

Нийтийн сонгогч гэж хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актыг тогтоох, төрийн байгууллага, нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд хяналт тавих, түүнчлэн хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын хэрэгжилтийг үнэлэх, нийтийн эрх ашгийг хөндсөн асуудлаар шийдвэр гаргахын өмнө төрийн байгууллага, албан тушаалтан, иргэн, хуулийн этгээд, мэргэжлийн шинжээчээс санал сонсох, мэдээлэл авах үйл ажиллагааг хэлнэ¹⁶.

Тухайлбал, ИТХ-аас ОНХС-ийн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн чанарыг сайжруулах талаар ЗДТГ-т үүрэг, чиглэл өгөхийн өмнө ОНХС-ийн асуудлаар хяналтын сонгогч зохион байгуулж болно. Асуудлыг мэддэг, хэрэгжүүлдэг, ашиг хүртдэг талуудыг сонссоноор ИТХ-ын шийдвэр бодитой, үр дүнтэй гарах юм. Нөгөө талаар эрх ашиг нь хөндөгдөж буй иргэд орон нутгийн удирдах үйл ажиллагаанд оролцож, асуудлаа хамтдаа шийдвэрлэж буй хэрэг мөн.

Сонгогчийн төрөл

1. **Хууль тогтоомжийн төслийн сонгогч** - Эрх бүхий этгээдээс боловсруулах хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний акт, нийтийн ашиг сонирхолд шууд хамааралтай эдийн засаг, нийгэм, байгаль орчны асуудлыг шийдвэрлэх, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хязгаарлахтай холбоотой асуудлуудаар хийнэ.
2. **Ерөнхий хяналтын сонгогч**- хууль, захиргааны хэм хэмжээний актыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий байгууллага, түүний удирдах албан тушаалтны үйл ажиллагаанд хяналт тавих, үнэлэх зорилготой.
3. **Төсвийн хяналтын сонгогч**- Төсвийн орлого ба зарцуулалттай холбоотой асуудлаар зохион байгуулна.
4. **Томилгооны сонгогч**-УИХ-аас албан тушаалтныг томилохтой холбогдуулан УИХ-ын нийт гишүүдийн 4\1 доошгүй хүсэлт гаргасан тохиолдолд зохион байгуулна.
5. **Захиргааны хэм хэмжээний болон төлөвлөлтийн сонгогч**- Захиргааны хэм хэмжээ ба бодлого төлөвлөлтийн төсөлд санал сонсох зорилготой.
6. **Орон нутгийн сонгогч**- УИХ ба Засгийн газар тодорхой асуудлаар орон нутагт очиж сонгогч зохион байгуулах эрхтэй.

Сонгогч ба хэлэлцүүлгийн ялгаатай тал юу вэ?

Монгол Улсад “Нийтийн сонгогчийн тухай хууль” 2015 онд батлагдан гарсан ч өнгөрсөн жилүүдэд ялангуяа орон нутагт төсвийн хяналтын сонгогч тун цөөн зохион байгуулагджээ. Зохион байгуулсан ч хууль, журмын дагуу бус ердийн хэлэлцүүлгийн хэлбэрээр хийх тохиолдлууд гарсаар байна.

¹⁶ Нийтийн сонгогчийн тухай хуулийн 5.1.1

Хүснэгт 2. 1. Сонсгол ба хэлэлцүүлгийн ялгаа

	Сонсгол	Хэлэлцүүлэг
Зохион байгуулагчид	<ul style="list-style-type: none"> • Хууль санаачлагч, • Төрийн байгууллага албан тушаалтан • Нутгийн өөрөө удирдах ба нутгийн захиргааны байгууллага 	Төрийн байгууллагаас гадна ТББ-ууд, аж ахуйн нэгж, эвсэл, холбоо зэрэг хуулийн этгээд болон иргэдийн хэн ч санаачлан зохион байгуулж болно.
Зорилго	Сонсголын үр дүнд зохион байгуулагчид (төрийн байгууллага) үнэн, бодит мэдээллийг (шийдвэр гаргахаас өмнө) оролцогч талуудаас олж авах зорилготой.	Оролцогч талууд мэдээлэл солилцох, үзэл бодлоо хуваалцах, нөлөөлөл хийх, нэгдсэн ойлголтод хүрэх гм өргөн хүрээний зорилготой байж болно.
Харилцааны үйлчлэл	Сонсох ажиллагаа бол нэг урсгалт үйл явц байдаг. Зохион байгуулагч тал (төрийн байгууллага) асуулт асууж, мэдээлэл авах ёстой болохоос оролцогчдын зүгээс Сонсгол даргалагч, зохион байгуулагчдаас асуулт асуух, мэдээлэл шаардах эрх байхгүй! Мэтгэлцэж, маргалдаж болохгүй!	Хэлэлцүүлэг бол хоёр ба түүнээс дээш талуудын харилцан мэдээлэл солилцох олон талт урсгал юм. Өөрөөр хэлбэл шийдвэр гаргагчид мэдээлэл өгөх, оролцогчид саналаа хэлэх, мэтгэлцэх, маргалдах, харилцан асуулт асуух нь чөлөөтэй.
Дэг	Сонсголд бэлтгэх, олон нийтэд зарлах, бүртгэх, үг хэлэх эрхээ авах, талуудыг оролцуулах (ажиглагч, шинжээч, хэвлэл мэдээлэл гм) зохион байгуулах үйл явц Нийтийн сонсголын тухай хууль ба журмаар хэрэгжинэ.	Зохион байгуулагчид хэлэлцүүлгийн дэгээ өөрсдөө тогтооно.
Даргалагч	Сонсгол даргалагч нь тухайн асуудлаар мэргэшсэн эсхүл туршлагатай, ашиг сонирхлын зөрчилгүй томилогдсон эсвэл сонгогдсон албан тушаалтан байна. Сонсгол даргалагч хуулиар хүлээсэн үүрэгтэй.	Хэлэлцүүлэг чиглүүлэгч хэлэлцүүлгийг санаачлан зохион байгуулагч талаас (Төр, ТББ, ААН, иргэн) хэн ч байж болох бөгөөд эсвэл хамтран удирдаж болно.
Оролцогчийн үүрэг	Сонсголд үг хэлнэ гэдэг баримт, нотолгоонд тулгуурласан объектив тайлбар, санал дүгнэлт байна. Үнэн зөв мэдээлэл өгөх хуулиар хүлээсэн үүрэгтэй.	Хэлэлцүүлэгт иргэд чөлөөтэй саналаа хэлэх ба заавал баримт, нотолгоо шаардахгүй тул субъектив шинжтэй.
Суудлын зохион байгуулалт	Сонсогч тал иргэд (ажиглагч) тал руу харж сууна. Үг хэлэх иргэд сонсогч тал руу харсан суудалд (индэр) сууна. Дуудагдсан албан тушаалтнууд тусдаа зассан суудалд суух нь зохимжтой ¹⁷ .	Оролцогчдын суудлын засалт чөлөөтэй, сонголттой байна.

Орон нутагт төсвийн хяналтын сонсголыг хэрхэн зохион байгуулах вэ?

“Нийтийн сонсголын тухай хууль”-д зааснаар нутгийн өөрөө удирдах, нутгийн захиргааны байгууллага дараах асуудлаар жил бүр төсвийн хяналтын сонсгол явуулах үүрэгтэй¹⁸. Үүнд:

- Орон нутгийн төсөв;
- Орон нутгийн хөгжлийн сангийн төсөв;
- Орон нутгийн өрийн бичиг, санхүүгийн бусад хэрэгсэл;
- Орон нутгийн гадаад болон дотоод зээл, буцалтгүй тусламж;
- Орон нутгийн баталгаа гаргах болон төсвийн өр, авлага үүсгэх аливаа бусад шийдвэр;

“Нийтийн сонсголын тухай хууль”-аар ИТХ эсвэл ЗДТГ-аас Төсвийн хяналтын сонсголыг зохион байгуулах үүрэгтэй.

¹⁷ Сонсголын үеийн суудлын засалтыг журамлаагүй тул олон улсын нийтлэг загварыг санал болгож байна.

¹⁸ Нийтийн сонсголын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 3. Төсвийн хяналтын сонсгол

Түүнчлэн иргэд, ТББ-ын зүгээс Төсвийн хяналтын сонсгол зохион байгуулах шаардлага хүргүүлэх эрхтэй байдаг.

Төсвийн хяналтын сонсголын бэлтгэл ажлыг хангах:

- Сонсголын товыг зарлах
- ИТХ-ын тогтоол гаргах
- Оролцогчдыг бүртгэх¹⁹
- Үг хэлэх, тайлбар тавих, мэдээлэл хийх хүмүүсийн нэрсийг нийтэд мэдээлэх.
- Урилгаар оролцуулах хүмүүсийн нэрсийг гаргах, урилга мэдээлэл түгээх.
- Аудитын дүгнэлт гаргуулах

Сонсголд оролцогчийн эрх ба үүрэг

Сонсгол даргалагч –Сонсгол даргалагч сонсголыг хуульд заасны дагуу удирдан зохион байгуулах, сонсголын асуудлыг тал бүрээс нь үнэн бодитойгоор тогтоох, сонсголд ач холбогдол бүхий нотлох баримтыг цуглуулах, үнэлэх, оролцогчийн эрх, үүргээ хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, сонсголын дэгийг сахиулах үүрэгтэй. Сонсгол даргалагч тухайн асуудлаар мэргэшсэн эсхүл туршлагатай, ашиг сонирхлын зөрчилгүй томилогдсон эсвэл сонгогдсон албан тушаалтан байна. Тухайлбал: ИТХ-аас Төсвийн хяналтын сонсголыг зохион байгуулах тохиолдолд Төсвийн хорооны дарга сонсгол даргалж болно. Сонсгол даргалагч сонсголын дэгийг тогтоож, хэв журмыг сахиулж, оролцогчийн эрх үүргээ хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.

Сонсголд оролцогч буюу үг хэлэх иргэд- Төсвийн тодорхой асуудлаар тайлбар, мэдээлэл хийх, санал, дүгнэлт гаргах зорилготой үг хэлэхээр бүртгүүлсэн иргэдийг хэлнэ. Тухайлбал: ОНХС-ийн төсвийн зарцуулалт, төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт хийсэн, түүнийхээ үр дүнг жишээ баримттай батлаж, нотлож чадах Иргэдийн хяналтын бүлгийн гишүүд байж болно.

Сонсголд тайлбар хийхээр ирсэн албан тушаалтан- Эрхэлж байгаа албан тушаалын хүрээнд сонсголд заавал оролцох, мэдээлэл, тайлбар өгөх үүрэг хүлээсэн төрийн албан хаагчийг хэлнэ. Тухайлбал: ОНХС-ийн хөрөнгөөр баригдсан шаардлага хангахгүй объектийг хүлээн авсан ажлын комиссын дарга, гишүүд байх жишээтэй. Тухайн албан хаагч холбогдох асуудлаар нэмэлт, мэдээлэл өгөх, тайлбар хийх, хурал даргалагчийн асуултад хариулах үүрэгтэй бөгөөд хэрвээ сонсголд үл хүндэтгэх шалтгаанаар ирээгүй бол хариуцлага хүлээнэ.

Ажиглагч- Сонсголд оролцохоор бүртгүүлсэн гэхдээ үг хэлэх, асуулт асуух эрхгүй оролцогчид юм.

Шинжээч- Тухайн асуудлаар мэргэшсэн мэргэжилтнүүд юм. Тухайлбал: төсөв, санхүүгийн шинжээчид сонсголд урилгаар оролцож болно. Сонсгол даргалагч шаардлагатай гэж үзвэл шинжээч оролцуулан дүгнэлт гаргуулах эрхтэй.

Хуулийн этгээд- Шаардлагатай гэж үзвэл төсвийн хөрөнгөөр ажил, үйлчилгээ гүйцэтгэсэн хуулийн этгээд буюу аж ахуйн нэгж, байгууллагын төлөөллийг оролцуулж, мэдүүлэг авч болно.

Хэвлэл мэдээллийн төлөөлөл- Хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөллийг сонсголд заавал оролцуулах хуулиар хүлээсэн үүрэгтэй.

¹⁹ Нийтийн сонсголын тухай журам 3.6, 3.7

Төсвийн хяналтын сонсголын дараалал:

- Танилцуулга. Сонсголын эхэнд даргалагч өөрийгөө болон сонсгол зохион байгуулагч байгууллагын төлөөлөл, сонсголын сэдэв, сонсголд дуудагдсан албан тушаалтан, үг хэлж тайлбар хийх иргэд, бусад оролцогчдын тоо, сонсголын дэг зэргийг 10 минутад багтаан танилцуулна.
- Сонсгол зохион байгуулах үндэслэлээ танилцуулах
- Дэг тогтоох
- Үг хэлэх
- Асуулт асуух
- Санал, дүгнэлт хэлэх
- Сонсголд дуудагдсан албан тушаалтнаас мэдээлэл авах
- Хуулийн этгээдийн мэдүүлэг
- Сонсголыг хаах.

Сонсох ажиллагааны үед тэмдэглэл хөтлөгдөж, аудио болон бичгийн хэлбэрээр тухайн байгууллагын албан ёсны цахим хуудсанд ажлын 5 өдрийн дотор байршигдсан байна.

Төсвийн хяналтын сонсголын үр дүнд хяналт тавих тухай

- Сонсголын үед хийгдсэн тэмдэглэл ба аудио бичлэгийг олон нийтэд түгээх,
- Нутгийн төлөөллийн ба захиргаан байгууллагаас иргэдэд үр дүнг мэдээлдэг болоход нөлөөлөх,
- Сонсголд оролцогч иргэд, ТББ-ууд сонсголын үр дүнд гарсан өөрчлөлт, ахиц, алхамыг хянах,
- Төсвийн хяналтын сонсгол жил бүр зохион байгуулах үүргээ биелүүлэхгүй бол нутгийн төлөөллийн болон захиргааны байгууллагыг Захиргааны хэргийн шүүхэд өгөх эрх зүйн үндэслэл бий.

Анхаарах зүйлс:

- **Зорилгоо тодорхойлох.** Сонсгол бол төрийн байгууллага (шийдвэр гаргагч нар) шийдвэр гаргахын өмнө тухайн асуудлын талаар богино хугацаанд үнэн бодит мэдээллийг талуудаас авах зорилготой.
- **Мэдээллээр хангах.** Сонсгол зохион байгуулахын өмнө мэдээлэл иргэддээ сайн өгөх хэрэгтэй байна. Тухайлбал: ОНХС-ийн хэрэгжилтийн талаар мэдээлэл аваагүй иргэд үр дүнтэй оролцож чадахгүй. Тиймээс үг хэлэхээр бүртгүүлсэн иргэд сэтгэл хөдлөлөөр хандаж, сонсголын ач холбогдлыг унагана. Иргэдийг тал бүрийн мэдээллээр хангаж байж үр дүнтэй сонсгол зохион байгуулагдана. Сонсголын үр дүн бэлтгэл ажлаас 50 хувь хамаарна.
- **Сонсгол ба хэлэлцүүлгийг хооронд нь холихгүй байх.** Сонсголыг иргэдтэй уулзалт хийх, хэлэлцүүлэгтэй хольж ойлгож болохгүй. Сонсголыг зохион байгуулахад гаргаж байгаа гол алдаа бол оролцогчид буюу үг хэлэхээр бүртгүүлсэн иргэд, ажиглагчид, аж ахуйн нэгжийн төлөөлөл сонсгол зохион байгуулагч талаас (жишээ нь ИТХ-ын төлөөлөгч нараас) асуулт асуудаг. Сонсголын зорилго бол сонсголыг зохион байгуулагчид буюу шийдвэр гаргагч нар үнэн зөв мэдээлэл цуглуулах явдал юм. Тиймээс сонсгол зохион байгуулагч тал (жишээ нь ИТХ-ын төлөөлөгчид) зөвхөн асуулт асууж, нэмэлт тодруулга авах эрхтэй.
- **Үг хэлэхээр бүртгүүлсэн иргэд бэлтгэлээ хангах.** Иргэд хэлэх үг, танилцуулах асуудал, баталгаа нотолгоогоо сонсох талд урьдчилан хүргүүлэх нь үр дүнтэй байдаг.

Ингэснээр сонсох тал ямар албан тушаалтныг оролцуулж, тайлбар гаргуулахаа урьдчилан шийдэж чадна.

- **Аудитын дүгнэлтийг сонсох.** Төсвийн хяналтын сонсголд аудитын дүгнэлтийг эхэндээ сонсох нь үр дүнтэй байдаг.
- **Сонсгол даргалагчийг оновчтой сонгох.** Зарим аймгуудад ИТХ-ын ажлын албаны дарга сонсгол даргалсан тохиолдол гарч байна. Хуулиар тэд сонсголыг зохион байгуулах буюу арын албыг хангах үүрэг хүлээсэн тул сонсгол даргалах эрхгүйг анхаарна уу.
- **Иргэдийг оролцоог хязгаарлахгүй байх.** ИТХ-ын ажлын албаны дарга төсвийн хяналтын сонсгол даргалах тохиолдлууд орон нутагт гарсаар байна. Хуулийн дагуу ажлын алба сонсголыг зохион байгуулах буюу арын албыг хангах үүрэг хүлээдэг. ИТХ-аас төсвийн сонсгол зохион байгуулж байгаа тохиолдолд ИТХ-ын төсвийн хороо, хяналтын дэд хорооны дарга удирдан явуулах нь илүү тохиромжтой.
- **Үр дүнгээ эргэн мэдээлэх.** Сонсгол зохион байгуулсны дараа үр дүнд суурилсан шийдвэрээ олон нийтэд ил тод мэдээлж, асуудлыг шийдвэрлэх нь сонсголын үр дүнд байх болно.

Мэдлэг бататгах дадлага ажил:

- Төсвийн хяналтын сонсгол зохион байгуулах жүжигчилсэн тоглолт хийнэ. Оролцогчдыг ИТХ-ын төлөөлөгчид, ЗДТГ-ын ажилтнууд, ИНБ, Компанийн төлөөлөл болгон хувааж, төсвийн хяналтын сонсголыг зохион байгуулах дадлага ажил хийлгэнэ.

Үнэлгээ:

- Оролцогчид төсвийн хяналтын сонсголын аргачлалыг эзэмшиж чадсан эсэхийг жүжигчилсэн тоглолтын үр дүнгээр үнэлнэ. Хичээлийн төгсгөлд **“Миний хувьд хамгийн хүнд нь юу байсан вэ”** буюу сургалтын төгсгөлд хамгийн хүнд сэдэв, эсвэл ойлгогдоогүй, эргэлзээтэй юу үлдсэн талаар багшаас асууж хариулт авна.

Эх сурвалж:

- Сосормаа Ч., “Иргэд төсвөө хянана” Төлөөллийн байгууллагын хяналтын чиг үүргийг иргэдийн оролцоотой чадавхжуулах тухай, Гарын авлага. УБ, 2020 он

Хууль, эрх зүйн баримт бичгүүд

1. Захиргааны ерөнхий хууль, 2015 он
2. Нийтийн сонсголын тухай хууль, 2015
3. Нийтийн сонсгол зохион байгуулах журам УИХ-ын 2017 оны 12 дугаар тогтоолын хавсралт
4. Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль, 2021 он

МОДУЛЬ 3.

АВЛИГЫН ЭСРЭГ ИРГЭДИЙН ХЯНАЛТ, ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХ АРГА ХЭРЭГСЛҮҮД



МОДУЛЬ 3. АВЛИГЫН ЭСРЭГ ИРГЭДИЙН ХЯНАЛТ, ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХ АРГА ХЭРЭГСЛҮҮД

Модулын танилцуулга

Хичээлүүд	Хамрах сэдэв	Дасгал ажил	Дасгалын зорилго
Хичээл 3.1. Нийгмийн аудит	<ul style="list-style-type: none"> • Нийгмийн аудит • Нийгмийн аудитын гол зорилго, арга хэрэгсэл 	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийг нийгмийн аудит хийх замаар үнэлэх дасгал	Оролцогчдод нийгмийн аудитийн ач холбогдол, хэрэгжүүлэх арга замыг ойлгуулж, бодит нөхцөл байдалд дадлагажих боломжийг олгоно.
Хичээл 3.2. Авлигын эсрэг кампанит ажил	<ul style="list-style-type: none"> • Авлигын эсрэг кампанит ажил • Авлигын эсрэг кампанит ажлыг зохион байгуулах алхамууд 	Авлигын эсрэг кампанит ажлын төлөвлөгөө боловсруулах	Авлигын эсрэг кампанит ажлыг төлөвлөх, хэрэгжүүлэх арга замыг ойлгож, зохион байгуулахад суралцана.

Хичээл 3.1. Нийгмийн аудит

Зорилго	Оролцогчдод нийгмийн аудитийн талаарх онолын мэдлэг олгож, түүний ач холбогдол, хэрэгжүүлэх арга замыг ойлгуулж, бодит нөхцөл байдалд дадлагажих боломжийг олгоно.
Зорилтот бүлэг	<ul style="list-style-type: none">• Иргэний нийгмийн сургагч багш нар
Дэд сэдвүүд	<ul style="list-style-type: none">• Нийгмийн аудит гэж юу вэ?• Нийгмийн аудитын зорилго• Нийгмийн аудитын арга хэрэгсэл
Зохион байгуулах алхмууд	<ul style="list-style-type: none">• Сэдэлжүүлэх дасгал ажил – 30 мин• Мэдлэг олгох – лекц – 60 мин• Мэдлэг бататгах дасгал – 60 мин• Дасгал ажлын үр дүн төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн аудитыг танилцуулж хэлэлцүүлэх – 60 минут• Сургалтын үнэлгээ – 30 минут
Сургалтын хэрэглэгдэхүүн	<ul style="list-style-type: none">• Хичээлийн слайд• Сургалтын техник: самбар, проектор, нотебүүк• Маркер, флипчарт, цаас, скоп

Сургагч багшид зориулсан зөвлөгөө

Нийгмийн аудит гэдэг нь аливаа төсөл, хөтөлбөр, үйлчилгээний гүйцэтгэл, үр дүн, тогтоосон стандартад нийцэж байгаа эсэхийг иргэдийн оролцоотойгоор шалгах, үнэлгээ хийх үйл явц бөгөөд энэ нь төсвийн хяналтаас өөр агуулга, арга зүйтэй гэдгийг ойлгуулах нь чухал.

Багуудын дасгал ажлаар хийсэн төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийн аудитыг танилцуулах хэсэгт илүү ач холбогдол өгч, хэлэлцүүлэг зохион байгуулан, багш тухай бүр тайлбар өгөх, сайжруулах санал зөвлөмжийг өгч ажиллана.

Мэдлэг олгох лекцийн товч агуулга:

Авлигын эсрэг иргэдийн хяналт нь иргэдийн оролцооны тодорхой нэг хэсэг бөгөөд иргэдийн үйл ажиллагаа нь илүү тодорхой чиглэлтэй, тодорхой арга хэрэгслүүдийг ашиглан төрийн байгууллагуудад хяналт тавихад чиглэгддэг.

Иргэдийн хяналт нь дээр дурдсан авлигын эсрэг шүгэл үлээх, олон нийтийн хэлэлцүүлэг, нийтийн сонголын хэлбэрүүдээс гадна нийгмийн аудит, төсвийн хяналт, мэдээлэл авах эрх гэх мэт тодорхой механизмуудыг ашиглан авлигаас урьдчилан сэргийлэх, илрүүлэхэд чиглэсэн байдаг.

Сэдэв 1. Нийгмийн аудит гэж юу вэ?

Нийгмийн аудит нь аливаа төсөл, хөтөлбөр, үйлчилгээ эцсийн хэрэглэгчид хүрсэн эсэх, гүйцэтгэл, үр дүн стандартад нийцсэн эсэхийг шалгах үйл явц бөгөөд авлигын эсрэг иргэдийн хяналтын арга хэрэгсэлд багтах чухал механизмын нэг юм.

Нийгмийн аудит нь төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын үйл ажиллагаа, төсөв, төсөл хөтөлбөрүүдэд хяналт тавих иргэдийн оролцоотой үнэлгээний процесс юм. Энэ нь

тухайн байгууллагын үйл ажиллагаа ил тод, хариуцлагатай, нийгмийн хэрэгцээ шаардлагыг хангаж байгаа эсэхийг үнэлэх зорилготой.

Энэхүү аргын хүрээнд зорилт, үр дүнг харьцуулан авч үзнэ. Нийгмийн аудит авлигын эсрэг иргэдийн хяналтын арга хэрэгсэл болох нь:

Ил тод байдал: Нийгмийн аудит нь төрийн байгууллагуудын үйл ажиллагаа, төсвийн зарцуулалт, хэрэгжүүлж буй төслүүдийг ил тод болгож, олон нийтэд мэдээллийг хүртээмжтэй болгодог.

Хариуцлага: Төрийн албан хаагчид болон байгууллагуудын үйл ажиллагааг ил тод болгож, иргэдийн өмнө хариуцлага хүлээлгэх зорилготой.

Иргэдийн оролцоо: Иргэд төрийн болон бусад байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавьж, өөрсдийн саналыг тусгах боломжтой болдог.

Үр дүнг нэмэгдүүлэх: Төсөл хөтөлбөрүүдийн үр дүнг, нийгэмд үзүүлэх эерэг нөлөөг сайжруулахад нийгмийн аудитын үнэлгээ тусалдаг.

Нийгмийн аудит нь иргэд, иргэний нийгмийн байгууллагууд, засаглалын байгууллагуудын хамтын ажиллагааны хүрээнд явагддаг бөгөөд хяналт тавих, мэдээлэл цуглуулах, үнэлэх замаар төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын үйл ажиллагааг сайжруулахад чиглэнэ.

Нийгмийн аудитын үйл явц:

- **Мэдээлэл цуглуулах:** Иргэд болон олон нийтийн бүлгүүд шаардлагатай мэдээллийг цуглуулж, тухайн байгууллагын төсөв, төсөл хөтөлбөрийн талаар судалгаа хийнэ.
- **Үнэлгээ хийх:** Цуглуулсан мэдээллийг ашиглан тухайн байгууллагын үйл ажиллагаа, зарцуулалтыг үнэлж, ил тод байдлыг шалгана.
- **Тайлан гаргах:** Үнэлгээний дүнг нийтэд нээлттэй тайлан гаргах замаар олон нийтийн дунд түгээнэ.
- **Засгийн газар эсвэл байгууллагад мэдэгдэл өгөх:** Үнэлгээний үр дүнг төрийн болон бусад холбогдох байгууллагуудад илгээж, хариуцлага хүлээлгэх, засварлах шаардлагатай асуудлыг мэдэгдэнэ.

Сэдэв 2. Нийгмийн аудитын гол зорилго, арга хэрэгсэл

Нийгмийн аудит нь тодорхой нэг үйл ажиллагааны үр дүнд үнэлгээ хийхэд чиглэсэн тодорхой үйл явц юм.

Нийгмийн аудитын арга хэрэгслүүд нь:

1. **Иргэдийн судалгаа (Citizen Report Cards):**
 - Иргэдийн үзэл бодол, санал, сэтгэгдлийг цуглуулж, төрийн үйлчилгээг үнэлэх арга. Энэ нь албан байгууллагын гүйцэтгэлийг хянах, сайжруулах мэдээллийг олж авахад ашиглагддаг.
2. **Оролцоот төсөвлөлт (Participatory Budgeting):**
 - Иргэд, олон нийт, иргэний нийгмийн оролцоотойгоор орон нутгийн төсөв, хөрөнгө оруулалт хэрхэн зарцуулагдахыг шийдвэрлэх үйл явц.
3. **Нийгмийн хяналтын самбар (Social Audit Boards):**
 - Олон нийтийн хяналт, үнэлгээг тогтмол явуулж, үр дүнг нь тайлагнах. Энэ нь орон нутгийн удирдлага, иргэдийн хоорондын харилцааг сайжруулахад чиглэнэ.
4. **Иргэдийн хяналтын хуудас, картууд (Citizen Charters):**

- Төрийн байгууллагууд өөрсдийн үйлчилгээг ил тод мэдээллэх зорилготой баталсан баримт бичиг. Үүнийг ашиглан иргэд байгууллагуудаас хариуцлагыг нэхэмжлэх боломжтой.

5. Оролцооны үнэлгээ (Participatory Evaluation):

- Олон нийт болон төр, хувийн хэвшлийн байгууллагууд хамтран төслүүдийн хэрэгжилт, гүйцэтгэлийг үнэлэх арга

Мэдлэг бататгах дасгал ажил

Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийг нийгмийн аудит хийх замаар үнэлэх дасгалыг ажиллуулна.

Аргачлал:

1. Оролцогчдыг 3-4 хүний багт хувааж, тус бүрд нэг төсөл эсвэл хөтөлбөр, түүний хэрэгжилтийн талаарх тайлангийн хураангуйг бэлтгэж өгнө.
2. Тухайн төсөл дээр ямар асуудлууд байсан, санхүүжилт нь хэрхэн зарцуулагдсан зэрэг үнэлгээг хийхэд шаардлагатай мэдээллийг урьдчилан бэлтгэж тарааж өгнө.
3. Багууд тухайн төсөлд нийгмийн аудит хийж, үнэлгээний тайлан гаргаж танилцуулна.
4. Баг тус бүрийн танилцуулгын дараа хэлэлцүүлэг өрнүүлж, багшийн зүгээс зарим тайлбар, залруулга, санал зөвлөмжийг өгөх замаар оролцогчдын мэдлэгийг бататгана.

Хичээл 3.2. Авлигын эсрэг кампанит ажил

Зорилго	<ul style="list-style-type: none">Оролцогчдод авлигын эсрэг кампанит ажлын ач холбогдлыг ойлгуулж, хэрхэн үр дүнтэй зохион байгуулах талаар мэдлэг олгох.
Зорилтот бүлэг	<ul style="list-style-type: none">Иргэний нийгмийн сургагч багш нар
Дэд сэдвүүд	<ul style="list-style-type: none">Авлигын эсрэг кампанит ажлын зорилгоАвлигын эсрэг кампанит ажлыг зохион байгуулах алхамууд
Зохион байгуулах алхамууд	<ul style="list-style-type: none">Сэдэлжүүлэх дасгал – 30 минутМэдлэг олгох – лекц – 60 минМэдлэг бататгах дасгал – 60 минКампанит ажлын төлөвлөгөөг танилцуулах, хэлэлцүүлэг – 60 минутСургалтын үнэлгээ 30 минут
Сургалтын хэрэглэгдэхүүн	<ul style="list-style-type: none">Хичээлийн слайдСургалтын техник: самбар, проектор, нотебүүкМаркер, флипчарт, цаас, скоч

Сургагч багшид зориулсан зөвлөгөө

Оролцогчдыг авлигын эсрэг кампанит ажлыг зохион байгуулах аргачлалд сургахын зэрэгцээ орон нутагтаа зохион байгуулах төлөвлөгөө боловсруулах дадлага ажил хийлгэж, улмаар хэрэгүүлэх хүсэл тэмүүлэл, сонирхол бий болгоход анхаарлаа хандуулна.

Оролцогчдыг аль болох шинэлэг арга, шинэ санаа, шийдэл гаргахад сэдэлжүүлж, дэмжлэг үзүүлнэ.

Сэдэлжүүлэх дасгал

Авлигын эсрэг кампанит ажлын жишээ, видео танилцуулга үзүүлж, оролцогчдоос дүгнэлт санал сонсож, хэлэлцүүлэг өрнүүлнэ.

Сэдэвтэй холбоотой товч мэдээлэл

Авлигын эсрэг кампанит ажил нь олон нийтийн ухамсарыг нэмэгдүүлж, авлигын эсрэг үйл ажиллагаанд иргэд, төрийн байгууллага, хувийн хэвшлийн хамтын оролцоог хангах арга зам юм. Эдгээр кампанит ажлууд нь зөвхөн төрийн түвшинд явагдахгүй, иргэдийн санаачилга, оролцоонд тулгуурлан хэрэгжих боломжтой.

Авлигын эсрэг кампанит ажлын зорилго

- Авлигын талаар олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх, нийгмийн ухамсарыг нэмэгдүүлэх.
- Иргэдийн оролцоог идэвхжүүлэх, тэдэнд авлигын талаарх мэдээлэл өгөх, мэдээлэл өгөх системийг дэмжих.
- Засаглалын ил тод байдал, хариуцлагыг нэмэгдүүлэх нөлөөллийн үйл ажиллагаа явуулах

Кампанит ажлыг зохион байгуулах үндсэн алхмууд

Алхам 1. Судалгаа, шинжилгээ хийх: Авлигын шалтгаан, нөхцөл байдлыг ойлгохын тулд дотоод болон олон улсын жишээнүүдийг судлах шаардлагатай. Кампанит ажлыг эхлүүлэхээс өмнө:

- Олон нийтийн авлигын талаарх ойлголт, мэдлэгийг судлах.
- Авлигын түвшин, төрлүүдийг судалж, ямар асуудлыг кампанит ажилд голлон анхаарахыг тодорхойлох.

Алхам 2. Зорилтот бүлгийг тодорхойлох: Кампанит ажлын хүрээнд аль бүлэгт анхаарлаа хандуулах вэ гэдгийг тодорхойлох нь чухал. Тухайлбал: Төрийн албан хаагчид, оюутнууд, иргэний нийгэм, хувийн хэвшлийнхэн гэх мэт.

Алхам 3. Мэдээлэл түгээх суваг, стратеги боловсруулах: Кампанит ажлын үр дүнтэй байдлыг хангахын тулд:

- Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, социал медиа, вебсайтууд, сурталчилгааны хэрэгслүүдийг ашиглана.
- Кампанит ажлын уриа, зурагт хуудас, богино видео зэргийг ашиглан олон нийтэд хялбар ойлгогдох контентууд бэлтгэх.
-

Алхам 4. Хэрэгжилтийг зохион байгуулах: Кампанит ажлын үеэр иргэдийн оролцоог нэмэгдүүлэх дараах арга замуудыг ашиглаж болно. Жишээ нь:

Шууд оролцуулах арга хэмжээ зохион байгуулах

- Кампанит ажлын хүрээнд сургалт, семинар, гарын авлага тараах зэрэг арга хэмжээг зохион байгуулж, иргэдэд хэрэгцээтэй мэдээлэл, мэдлэг олгох.
- Биечлэн оролцох, асуулт, хариултын хэлбэртэй хурал уулзалтууд зохион байгуулах.
- Оролцогчдоор авлигын эсрэг кампанит ажилд зориулсан зурагт хуудас, постер бүтээлгэх. Энэ нь тэдний санааг илэрхийлэх, олон нийтэд хүргэх ур чадварыг нэмэгдүүлж, авлигын эсрэг уриалгын хүчийг ойлгоход тусална.

Сошиал медиад хаштаг ашиглах кампанит ажил явуулах

- #АвлигынЭсрэг хаштаг ашиглан Twitter, Instagram дээр кампанит ажлыг өрнүүлэх.).
- Facebook групп байгуулах: Авлигын эсрэг мэдээлэл солилцох, хэлэлцүүлэг хийх Facebook групп байгуулах.
- Онлайн уулзалт, хэлэлцүүлэг, вебинар зохион байгуулах.
- Онлайн санал асуулга явуулах, сонирхогч талуудтай цахимаар холбогдох.
- Иргэд цахимаар мэдээлэл авах, санал өгөх боломжтойгоор цахим оролцоог дэмжих хэрэгсэл бий болгох.

Сошиал медиаг ашиглан авлигын эсрэг кампанит ажил явуулахад зориулсан стратеги, контент хөгжүүлэх зөвлөмжүүдийг Hootsuite болон Buffer зэрэг сошиал медиа удирдлагын хэрэгслүүдийн блог, вэбсайтуудаас судалж болно.

Сурталчилгаа болон урамшуулал

- Кампанит ажлын хүрээнд сурталчилгааны хөтөлбөр хэрэгжүүлж, кампанит ажилд оролцсон иргэдийг урамшуулах, тэдэнд хөнгөлөлт, шагнал санал болгох.
- Оролцогчдын сэдэлжүүлэх, олон нийтийн оролцоог дэмжих замаар кампанит ажлын үр дүнг нэмэгдүүлэх.

Иргэний нийгмийн байгууллагуудтай хамтрах

- Иргэний нийгмийн байгууллагуудыг кампанит ажилд татан оролцуулж, тэдгээрийн сүлжээ, туршлагыг ашиглан олон нийтийг кампанит ажилд татан оролцуулах.
- Олон нийтийн дунд нэр хүндтэй иргэд, нийгмийн идэвхтэй бүлгүүдээр дамжуулан оролцоог нэмэгдүүлэх.

Алхам 5. Үр дүнг үнэлэх: Кампанит ажлын дараа үр дүнг үнэлж, цаашид хэрхэн сайжруулах талаар санал асуулга хийх, тайлан гаргах.

Кампанит ажлын үр дүнгийн үнэлгээ:

- Кампанит ажлын дараа олон нийтийн хандлагыг хэмжиж, кампанит ажилд хичнээн хүн оролцсон, ямар үр дүн гарсныг дүгнэх шаардлагатай.
- Олон нийтийн зүгээс авлигын талаарх ойлголт нэмэгдсэн эсэхийг судалж, цаашид хэрэгжүүлэх стратегийг тодорхойлох.

Авлигын эсрэг кампанит ажлын жишээнүүд:

- **"I Paid a Bribe" (Энэтхэг):** Энэ платформ нь иргэдээс авлигын талаар мэдээлэл цуглуулж, авлигын хэлбэрийг баримтжуулан, олон нийтэд ил болгосон.
- **Transparency International-ийн кампанит ажил:** Олон улсад Transparency International байгууллага авлигын талаар олон нийтийг соён гэгээрүүлэх кампанит ажил явуулж, цахим платформуудыг ашиглан мэдээлэл түгээдэг.

Авлигын эсрэг кампанит ажилыг төрийн байгууллагууд зохион байгуулах боломжтой ч энэ нь зөвхөн төрийн байгууллагын хүрээнд хязгаарлагдахгүй, иргэдийн оролцоо, идэвх санаачилгаар амжилттай хэрэгжих боломжтой. Олон нийтийн дэмжлэг, оролцоог нэмэгдүүлэхэд кампанит ажил нь чухал үүрэгтэй.

Мэдлэг бататгах дасгал ажил

Оролцогчдыг баг болгон хуваарилж, авлигын эсрэг кампанит ажлын төлөвлөгөө боловсруулах дасгал ажиллуулна.

- Багуудад үйл ажиллагааны зорилго, зорилтууд, маркетингийн стратеги, санхүүжилтийн эх үүсвэр гэх мэтийг тодорхойлох зөвлөмжүүдийг сургагч багшийн зүгээс өгч ажиллана.

Сургалтын үнэлгээ

- Багуудын ажлаар сургалтыг үнэлнэ.
- Хэрэгжих боломжтой, шинэ санаа бүхий кампанит ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд хамтран ажиллах боломжийг тодорхойлно.

Ашиглах материал эх сурвалжууд:

Авлигын эсрэг эвентүүдийн бичлэг, контентуудыг дараах эх сурвалжуудаас үзэх боломжтой:

1. **Авлигатай тэмцэх газар (АТГ):** АТГ-аас зохион байгуулсан авлигын эсрэг арга хэмжээ, сургалт, эвентүүдийн бичлэгийг тэдний албан ёсны YouTube суваг болон вэбсайтаас үзэж болно.
[IAAC](#)
2. **"Авлигын эсрэг нэгдье" видео:** Авлигатай тэмцэх газрын бэлтгэсэн энэхүү видео нь авлигын эсрэг нэгдэн тэмцэхийг уриалсан контент юм.
[YouTube](#)
3. **"Авлигын эсрэг хамтдаа" YouTube суваг:** Энэхүү суваг нь авлигын эсрэг тэмцэлд зориулсан олон төрлийн видео контентуудыг агуулдаг.
[YouTube](#)
4. **"Би авлигатай ингэж тэмцэнэ" уралдаан:** Авлигатай тэмцэх газраас оюутан, сурагчдын дунд зохион байгуулсан энэхүү уралдааны талаархи мэдээллийг GoGo мэдээний сайтаас уншиж болно.
[Gogo.mn](#)

Унших материал: Transparency International Campaigns

Унших материал: UNODC Anti-Corruption Resources